



# САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ



Japan  
Fund for  
Poverty  
Reduction

Төслийн дугаар: P44112-01  
2013 оны эхний хагас жилийн тайлан

## САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

### 2013 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Хугацаа: 2013 оны 1 дүгээр сарын 01-ээс  
2013 оны 6 дугаар сарын 30

Улаанбаатар хот  
Санхүүгийн Зохицуулах Хороо

**Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээжийг нэмэгдүүлэх төслийн баг 2013 оны оны эхний хагас жилд “Хамтарсан ажлын хэсгийн санамж бичиг”, “Төсөл хэрэгжүүлэх заавар”, 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдлага болгож дараах ажлуудыг гүйцэтгэв.**

## **АГУУЛГА**

- 1. Ерөнхий мэдээлэл**
  - 1.1. Төвч танилцуулга**
    - 1.1.1. Төслийн үр өгөөж**
    - 1.1.2. Төслийн зардал, түүний ангилал**
  - 1.2. Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт**
    - 1.2.1. Төслийн удирдах хороо**
    - 1.2.2. Удирдлага, хүний нөөцийн талаар**
      - 1.2.2.1. Төслийн зохицуулагчид**
      - 1.2.2.2. Төслийн үндэсний зөвлөхүүд**
      - 1.2.2.3. Мониторинг үнэлгээний баг**
      - 1.2.2.4. Төслийн олон улсын зөвлөхүүд**
        - 1.2.2.4.1 ХЗХ-ны чадавхижуулалт, сургалтын ОУ-ын зөвлөх**
        - 1.2.2.4.2 ХЗХ-ны хяналт шалгалтын ОУ-ын зөвлөх**
        - 1.2.2.4.3 Олон улсын Санхүүгийн боловсролын зөвлөх**
        - 1.2.2.4.4 Олон улсын хуулийн зөвлөх**
- II. Тайлант хугацаан дахь төсөл хэрэгжилтийн үйл ажиллагаа**
- 2.1. Төслийн менежмент**
- 2.2 БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ А: ХЗХ-ДЫН ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН СУРГАЛТ; ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ**
  - 2.2.1. ХЗХ-ны зах зээлийн тогтворжилт**
  - 2.2.2. ХЗХ-ны зах зээлийн зохицуулалт**
  - 2.2.3. ХЗХ-ны чадавхийн үнэлгээ болон сургалт чиглэлээр**
  - 2.2.4. Хадгаламж зээлийн хоршооны хууль, дүрэм, журмууд болон үйл ажиллагаа, төслийн үр ашгийн талаар телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах хүрээнд**

**2.3. БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ В: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ТУЛГУУРЛАСАН НАСАНД ХҮРЭГСДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ**

**2.3.1. Мэдээллийн хэрэгсэлд суурилсан насанд хүрэгчдийн санхүүгийн боловсрол**

**2.3.2. Газар дээрх судалгаа**

**2.3.3. Санхүүгийн боловсролын тухай телевизийн цуврал хийх тендерийг сонгон шалгаруулах**

**2.4. Бүрэлдэхүүн С: Мониторинг үнэлгээний систем нэвтрүүлэн хэрэгжүүлсэн, түүвэрлэн үнэлэх**

**2.4.2. Төсөл хэрэгжилт дэх жендэрийн болон бусад бүлгүүдийн оролцооны үйл явц**

**III. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЛТЭД**

**3.1. Төсөл хэрэгжилтэд тулгарсан асуудлууд**

**3.2. Дараагийн улиралд хийх үйл ажиллагааны хөтөлбөр (Төслийн хэсэг тус бүрээр)**

**4. 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

**5. Зөвлөхүүдийн оролцоо болон ажлын үр дүн**

**IV. Санхүүгийн болон худалдан авалтын арга хэмжээ**

**4.1.Төслийн худалдан авалт**

**4.2. 2013 оны үйл ажиллагааны эхний хагас жилийн санхүүжилт**

**4.3. Төслийн зардал (жилээр)**

## ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛУУДЫН ЖАГСААЛТ

<b>Нэрс</b>	<b>Байгууллага</b>	<b>Албан тушаал</b>
Ян Хансэн	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Ахлах эдийн засагч
Э.Энэрэлт	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Хөрөнгө оруулалтын эдийн засагч
Ж.Батцэнгэл	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Төслийн шинжээч
Х.Доржханд	Сангийн яамны Төслийн хэрэгжилт, зохицуулалтын газар	Дарга
Х.Бум-Эрдэнэ	Санхүүгийн зохицуулах хороо	Ажлын албаны дарга
Н. Оюунчимэг	Санхүүгийн зохицуулах хороо	Бичил санхүүгийн газрын дарга
Ц.Мягмар-Очир	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв	Гүйцэтгэх захирал
Ш. Гоохүү	Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо	Захирал

## ВАЛЮТЫН ХАНШ

(2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн ханшаар тооцов)

Валютын нэгж – төгрөг(MNT)  
\$1.00 = MNT1,446.17

## ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн хөгжлийн банк
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ХЗХ-д	Хадгаламж зээлийн хоршоод
ЯБЯС	Ядуурлыг бууруулах Японы сан
МХЗХХ	Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо
МХСМТ	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТУХ	Төслийн удирдах хороо

## ҮГСИЙН ТАЙЛБАР

Аймаг – орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж  
сум – дүүрэг

text-in – радио, телевизээр цацсан мэдээллийн талаар болон асуултын хариултыг үүрэн  
утасны мессежээр хүлээн авах

## ТЭМДЭГЛЭГЭЭ

Энэхүү тайланд, "\$" тэмдэг нь америк долларыг илтгэнэ.

## ТӨСЛИЙН ЦАГ ХУГАЦААНЫ ТОВЬЁОГ:

Японы Засгийн газрын төсөл баталсан өдөр:	2010 оны 11 дүгээр сарын 9
АХБ-ны төсөл баталсан огноо:	2010 оны 11 дүгээр сарын 25
Буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурсан өдөр: (БТ-ийн хүчин төгөлдөр болсон хугацаа):	2012 оны 1 дүгээр сарын 17
Төсөл дуусгавар болох огноо:	2015 оны 7 дугаар сарын 31
Төсөл эхлүүлэх ажлын хэсэг ажилласан өдөр:	2012 оны 6 дугаар сарын 11-14
Төслийн харилцан ойлголцлын санамж бичигт (санамж бичиг) өөрчлөлт оруулан, үйл ажиллагаатай танилцаж, төсөл шилжүүлсэн.	2012 оны 11 дүгээр сарын 21-22

**“ЯДУУ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСЛИЙН  
2013 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН  
/2013.01.01-2013.06.30/**

**I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

**1.1. Товч танилцуулга**

1. Энэхүү буцалтгүй тусалтгүй тусламжийн гэрээ нь 2012 оны 1 дүгээр сарын 17-ний өдөр Монгол улсын Сангийн яам (СЯ), Азийн хөгжлийн банк (АХБ) болон Санхүүгийн зохицуулах хорооны (СЗХ) хооронд гарын үсэг зурагдсан.

2. Төслийн хүрээнд Хадгаламж, зээлийн хоршоодыг (ХЗХ) чадавхжуулах, салбарыг бэхжүүлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар Монгол улсын ядуу болон эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төслийн баримт бичигт тусгагдсан. Төсөл нь ХЗХ-дын Чадавхийн үнэлгээ болон сургалт, Зохицуулалт, Хяналт шалгалт, Санхүүгийн боловсрол гэсэн үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй.

3. 2012 оны 6 дугаар сарын 11-ээс 14-ний өдрүүдэд “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилготой АХБ болон СЗХ-ны хамтарсан ажлын хэсэг төслийн баг, үндэсний болон Олон улсын (ОУ) зөвлөхүүдтэй хамтран цаашдын төслийн үйл ажиллагааны чиглэлийг боловсруулсан. Энэхүү Ажлын хэсгийн уулзалтын хамтын ажиллагааны санамж бичигт АХБ болон СЗХ-ны харилцан ойлголцол мөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцэн тохиролцож асуудлуудыг тусган харилцан зөвшилцөлд хүрч (СЯ) танилцуулсан.

4. Төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааг цаг хугацаанд тохируулан шинэчлэх, сайжруулахад төслийн баг нь үндэсний болон ОУ-ын зөвлөхүүдийн санал зөвлөмжтэй уялдуулан АХБ-тай харилцан зөвшилцөж хамтран ажиллаж 2012 оны 7 дугаар сарын 31-нд төслийн баримт бичгийн албан ёсны хөрвүүлэг, төсөл хэрэгжилтийн хуваарь, санхүүжилтийн төлөвлөгөө болон төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ирүүлсэн.

5. Энэхүү төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой зарим зохицуулалт, хэрэгжилтийн хуваарь болон зардлын зүйл ангид өөрчлөлт оруулахаар харилцан ойлголцлын санамж бичигт 2012 оны 7 дугаар сард СЯ, СЗХ-ны холбогдох төлөөлөл саналаа өгсөн харин АХБ-аас албан ёсоор баталгаажуулаагүй болно.

**Төслийн зорилго:**

6. ХЗХ-дыг чадавхижуулах, салбарыг бэхжүүлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар Монгол улсын ядуу болон эмзэг бүлгийн (амьжиргааны түвшингээс арай дээгүүр орлоготой хэдий ч эрсдэлд орж болзошгүй) иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Төслийн хүрээнд:

- (i) шинэ хууль, эрх зүйн дагуу ХЗХ-ны зохицуулалтууд, хяналт-шалгалтын системийн тогтолцоог сайжруулан нэвтрүүлнэ;



- (ii) газар дээрх үзлэг, шалгалт, тусгай зөвшөөрөл, ХЗХ бүрд үнэлгээ зэрэглэл тогтооно;
- (iii) ХЗХ-дын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сургалтын шинэ аргачлалыг нэвтрүүлнэ;
- (iv) насанд хүрэгчдэд санхүүгийн суурь боловсролыг телевизийн цуврал драм, үүрэн утасны text-in системээр дамжуулан хүргэнэ;
- (v) гарч ирэх үр дүнг тодорхойлохдоо санамсаргүй түүвэрлэх аргачлалаар нарийвчилсан үнэлгээ хийх болно.

### 1.1.1. Төслийн үр өгөөж

7. Төсөл хэрэгжсэнээр СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан нийт 158 ХЗХ-дын чадавх сайжирч, хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа нь тогтворжино. Үүнд:

- (i) Бүртгэлтэй ХЗХ-дын 90% нь одоогийн мөрдөгдөж байгаа хууль журамд нийцэж ажилладаг болно.
- (ii) Бүртгэлтэй ХЗХ-дын 90% нь үнэлгээ зэрэглэл тогтоолгосон байна.
- (iii) Сонгосон ХЗХ-дын удирдлагын сургалтын арга барил нь ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагааг дээшлүүлэхэд нөлөөлнө (3 сургалтын арга барилын сонгогдсон 1 нь 50% үр дүнгээ өгөх).
- (iv) Санхүүгийн боловсрол олгох ТВ сургалтын олон төрлийн сонголттой асуултад үнэн зөв хариулах (мессежбичих) өрхийн хувь 50%-д хүрнэ.
- (v) ХЗХ-ны гишүүн болон санхүүгийн боловсрол олгох нэвтрүүлгийн үзэгчдээс ядуурал нь бодитоор буурсан өрхийн хувь 35%-д хүрнэ.

### 1.1.2. Төслийн зардал, түүний ангилал

8. Төслийн нийт зардал: 2 500 000 ам доллар

Но	Төсвийн ангилал (Хэсэг тус бүрээр)	А хэсэг:	В хэсэг:	С хэсэг:	Нийт	Хувь %
1	Тоног төхөөрөмж, бусад хангамжууд	114 000		30 000	144 000	6
2	Сургалт, Семинар, Олон нийтэд зориулсан арга хэмжээ	224 720	396 000	19 000	639 720	26
3	Зөвлөхийн үйлчилгээ	600 100	136 200	124 800	861 100	34
4	Төслийн удирдлага			372 800	372 800	15
5	Бусад: газар дээрхи санхүүгийн үнэлгээ, ХЗХ-дын чадавхийн үнэлгээ, хөндлөнгийн аудит	264 000	50 000	15 200	329 200	13
6	Төлөвлөгөөгүй зардал	122 380	15 800	15 000	153 180	6
	<b>Дүн</b>	<b>1 325 200</b>	<b>598 000</b>	<b>576 800</b>	<b>2500 000</b>	<b>100</b>
	Засгийн газрын оруулах хувь оролцоо	120 000	52 000	88 800	260 800	
	Бусад хувь оролцоо (ХЗХ-дын холбоо)	103 600			103 600	
	<b>Нийт дүн</b>	<b>1 548 800</b>	<b>650 000</b>	<b>665 600</b>	<b>2 864 400</b>	

## 1.2. Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт

### 1.2.1. Төслийн удирдах хороо

9. Төслийн удирдах хорооны (ТУХ) бүрэлдэхүүн нь СЗХ, Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо (МХЗХХ), Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв (МХСМТ) болон Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо (МХҮНХ)-ны захирлын түвшний төлөөлөгчдөөс бүрдсэн бөгөөд СЗХ-ны төлөөлөгч нь Төслийн удирдах хорооны дарга байж, төслийн хэрэгжилтийн ерөнхий удирдамж болон стратегийн чиглэлээр удирдлагаар хангаж ажиллаж байна.

10. СЗХ-ны 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 157 дугаар тогтоолоор ТУХ-ны бүрэлдэхүүнийг албан ёсоор байгуулагдсан бөгөөд СЗХ-ны 2012.10.23-ны өдрийн хурлын 321 тоот тогтоолоор ТУХ-ны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. ТУХ-ны бүрэлдэхүүнд:

1. СЗХ-ны Ажлын албаны дарга бөгөөд ТУХ-ны дарга - Х.Бум-Эрдэнэ
2. МХЗХҮХ-ны дарга - Ш.Гоохүү
3. МХСМТ-ийн гүйцэтгэх захирал - Ц.Мягмар-Очир
4. СЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга - Б.Батбаяр
5. СЗХ-ны Бичил санхүүгийн газрын дарга бөгөөд Төслийн захирал - Н.Оюунчимэг
6. СЯ-ны Төслийн санхүүжилт, зохицуулалтын газрын мэргэжилтэн - М.Аясгалан
7. МХҮНХ-ны тэргүүлэгч гишүүн - Ч.Алтангааяа

11. ТУХ нь 2013 оны эхний хагас жилийн байдлаар 3 удаа хуралдаж 4 асуудал танилцуулж, 4 асуудал хэлэлцснээс ТУХ-ны 1 асуудал тэмдэглэлээр, 3 асуудал тогтоолоор шийдвэрлэгдсэн.

- (i) ТУХ-ны 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн хуваарь, худалдан авалтын төлөвлөгөө, үнэлгээний эцсийн хэлэлцүүлгээс гарсан үр дүн, үнэлгээчдийн сургалт, үнэлгээ хийх талаар хэлэлцсэн. Уг хурлаар хуралд оролцсон гишүүдын саналаар “Төслийн 2013 оны төлөвлөгөө”-г зарчмын хувьд батласан. Гэхдээ уг төлөвлөгөөнд санал өгөхөөр бол нэг дэх өдрөөс өмнө емейл-ээр ирүүлэхийг сануулсан. Харин Төслийн санхүү, захиргааны зохицуулагч Б.Хишгээ нь Үндэсний санхүүгийн боловсролын судлаач, Төслийн олон нийтийн харилцаа ба зөвлөгөөний үндэсний зөвлөхийн эхлэлтийн тайлан, ажлын төлөвлөгөө гарсны дараа худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орно гэсний дагуу уг төлөвлөгөө батлахыг хойшлуулсан. МХЗХҮХ, МХСМТ-ийн орон тооны бус ажиллах үнэлгээчид, сургагч багш, зөвлөхийн хөлс болон үнэлгээчдийн сургалтын төсөв шийдвэрлэхийг хүссэн 2-13, 62 тоотуудыг бусад асуудлаар танилцуулахад ТУХ-ны гишүүдийн зүгээс СЗХ-ны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд энэ асуудлыг дахин ярилцахаар хойшлуулсан.
- (ii) ТУХ-ны 2 дахь удаагийн хурал 2013 оны 2 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж уг хурлаар Үндэсний санхүүгийн боловсролын судлаач Д.Дамдинжав, Төслийн олон нийтийн харилцаа ба зөвлөгөөний үндэсний зөвлөх Д.Гэрэлт-Од нар эхлэлтийн тайлан болон үйл ажиллагааны хэрэгжилтийн хуваариа Хорооны гишүүдэд танилцуулав. Уг хурлаар Үндэсний зөвлөх Д.Дамдинжавын эхлэлийн тайланг хангалттай гүйцэтгэсэн гэж үзэв. Харин Үндэсний зөвлөх Д.Гэрэлт-Од эхлэлийн тайланг хэт ерөнхий байна гишүүнийн саналыг тусган дахин боловсруулахаар болов. Түүнчлэн телевизорын олон ангит киног хийхдээ эхлээд 6 ангит киног 3 студиор 2, 2

ангиар, 1 ангийг нэг цаг үргэлжилэх, сэдвийн хувьд хязгаарлахгүй, тэгэхдээ бүх студи дээр яг адилхан мессежүүдийг гаргаж өгнө. Киноны товч танилцуулга гараад ирэхээр хамгийн сайн хийсэн 3 студи сонгоно. Энэ сонгосон студид зардлаа өгөөд киног хийлгэнэ. Зөвлөхүүдийн анхаарах зүйл бол үнэлгээ өгөх судалгаа. Энэ судалгаанаас гарсан саналын үр дүнг үндэслэн хамгийн сайн гэсэн нэг студитой шууд гэрээ байгуулж үлдсэн 24 ангит киног хийлгэхээр болов. Мөн Төслийн ТУХ-ны дарга Х.Бум-Эрдэнэ Төслийн зохицуулагч Б.Хишгээд кино хийхтэй холбоотой ажлын төлөвлөгөө гаргахыг үүрэг болгосон.

- (iii) ТУХ-ны 3 дахь удаагийн хурал 2013 оны 4 дүгээр сарын 04-ны өдөр хуралдаж уг хурлаар төслийн баримт бичигт оруулах өөрчлөх, мөн хэрэгжилт нь хоцрогдолтой байгаа ажил, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэв. Уг хурлаар Төслийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, төслийн баримт бичигт тусгагдсан ажлууд, хүрэх үр дүнг нарийвчлан тодорхойлох зорилгоор төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах саналыг бэлтгэх Ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:

Ахлагч	Н.Оюунчимэг	Төслийн захирал
Гишүүд	Ц.Мягмар-Очир	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвийн гүйцэтгэх захирал
	Д.Гэрэлт-Од	Олон нийтийн харилцааны үндэсний зөвлөх
	Д.Дамдинжав	Санхүүгийн боловсролын судлаач
	Т.Оюунчимэг	ХЗХ-ны чадавхийн үнэлгээ, сургалтын үндэсний зөвлөх

нар байв. Энэхүү ажлын хэсэг нь саналаа 2013 оны 4 дүгээр сарын 09-ний дотор гаргаж Төслийн удирдах хорооныдаргад танилцуулахыг үүрэг болгосон.

Тус хурал дээр Төслийн дарга Н.Оюунчимэг СЯ-аас Б.Батбаяр гишүүн ТУХ-ны бүрэлдэхүүнд байдаг боловч хуралд ирдэггүй. Одоо ажлаа өгсөн. Б.Аясгалан ТУХ-ны гишүүн боловч албан тушаал нь өөрчлөгдсөн гээд Г.Цэлмэг оронд нь 1 удаа хуралд оролцсон боловч албан ёсны тушаал шийдвэр нь ирээгүй. СЯ-аас ТУХ-нд төлөөлөл байхгүй, оролцоо муу байгаа талаар мэдэгдсэн.

Уг ТУХ-ны хурлаас байгуулагдсан ажлын хэсэг төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах саналаа боловсруулж ТУХ-ны дарга Х.Бум-Эрдэнэд танилцуулсан. Уг саналыг СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 12-ны 1/1466 тоот албан бичгээр СЯ болон АХБ-нд хүргүүлсэн.

Мөн тус төслийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд СЯ-ны Санхүүгийн бодлогын асуудал хариуцсан газрын дарга/Б.Батбаяр/,Зээл, тусламжийн бодлого, хамтынажиллагааны газрын мэргэжилтэн /М.Аясгалан/ нар байсан боловч эдгээр ажилтнууд өөр ажилд шилжиж ажлаас чөлөөлөгдсөн тул албан ёсны төлөөлөл байхгүй болсон. Иймээс төслийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шийдвэр гаргах түвшний эрх бүхий ажилтны нэрийг ирүүлэх хүсэлтийг СЯ-нд хүргүүлсэн. Үүний дагуу СЯ-ны 2013 оны 7-2/2530 албан тоотой тус яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын мэргэжилтэн Э.Болорыг ТУХ-нд гишүүнээр томилсон тухай мэдэгдсэн. Үүнтэй холбогдуудан төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт

оруулах тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн СЗХ-ны 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч асуудал хойшлогдсон.

### **1.2.2. Удирдлага, хүний нөөцийн талаар**

12. Төсөл нь анхнаасаа төсөл хэрэгжүүлэгч нэгжийг байгуулахгүйгээр СЗХ нь өөрсдийн хүчин чадалд тулгуурлан хэрэгжүүлэхээр зохион байгуулагдсан. Төслийг СЗХ-ны Бичил санхүүгийн газар (БСГ)-т байгуулах ба газрын дарга бүх үйл ажиллагааг удирдан явуулна. СЗХ-ны БСГ-ын Хадгаламж зээлийн хоршооны хэлтэс (ХЗХХ) болон тус газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс (БТХ)-тэй төслийн хэрэгжүүлэлтийн үйл ажиллагаанд шууд холбогдон хамтран ажиллаж байна. Төслийн гүйцэтгэгч байгууллага болох МХСМТ болон МХЗХХ нь төслийн үйл ажиллагаанд хамтран ажиллагч, оролцогч байгууллагын хувьд хөдөө, хотод үйл ажиллагаа явуулж буй бүх ХЗХ-дын чадавхийг тодорхойлсон. Одоо сургалтын төлөвлөгөө болон сургалтууд зохион байгуулах, хэрэгжилтийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

#### **1.2.2.1. Төслийн зохицуулагчид**

13. Төсөл нь санхүү, захиргааны болон хангамж, тайлагнал хариуцсан орон тооны 2 зохицуулагчтай байхаар төслийн баримт бичигт тусгагдсан. Үүний дагуу Төсөл нь санхүү, захиргааны болон аж ахуй, тайлагналт хариуцсан орон тооны 2 зохицуулагчдын ажлын зарыг Өдрийн сониноор зарлаж, Төслийн санхүү, захиргааны зохицуулагчаар Б.Хишгээ, Хангамж, тайлагнөл хариуцсан зохицуулагчаар Г.Золжаргал нарыг сонгон АХБ-наас зөвшөөрөл авч, гэрээ байгуулан 2012 оны 3 дугаар сарын 15-аас эхлэн ажиллуулсан.

14. Гэвч төслийн аж ахуй, тайлагналтын зохицуулагч Г.Золжаргал өөрийн хүсэлтээр 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдөр ажлаа өгсөн тул АХБ-тай зөвшилцөн ажлын байрны зарыг “Өдрийн сонин”, емейлд тулгуурласан зарыг СЗХ, АХБ-ны цахим хуудас дээр тавьсан бөгөөд зарын дагуу 3 хүн материал ирүүлсэн. Төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд, СЯ-ны төлөөлөл багтсан зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний ажлын хэсэг нь АХБ-ны зөвлөх үйлчилгээ авах тухай журмын дагуу төслийн аж ахуй, тайлагналтын зохицуулагчаар П.Байгалмааг шалгаруулан АХБ-ны зөвшөөрөлтэйгээр СЗХ-ны газрын дарга бөгөөд төслийн захиралтай гэрээ байгуулан 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажиллуулж байна.

#### **1.2.2.2. Төслийн үндэсний зөвлөхүүд**

15. Төслийн хугацаанд үндэсний 4 зөвлөх гэрээгээр ажиллахаар төслийн баримт бичигт тусгагдсаны дагуу үндэсний зөвлөхүүд сонгон шалгаруулах тухай ажлын байрны зарыг удаа дараа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан бөгөөд ажлын байрны шаардлагад нийцсэн хангалттай материал ирээгүй, ирсэн хүсэлтүүдээс санхүүгийн боловсролын судлаач, олон нийттэй харьцах зөвлөхүүдийг сонгон шалгаруулсан боловч холбогдох зардлын улмаас ажлын саналаас татгалзсан хариу өгч байсан. Харин ХЗХ-ны чадавхижуулалт, сургалтын үндэсний зөвлөхөөр Т.Оюунчимэг 2012 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн нийт 24 хүн-сар ажиллахаар гэрээ байгуулан, хийх ажил үүргээ төслийн хэрэгжилтийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна.

16. Дээрх нөхцөл байдлын талаар 6 дугаар сард ирж ажилласан АХБ-ны ажлын хэсэгт мэдэгдэж, ажлын хэсгийн зүгээс Монгол улсад хэрэгжиж байгаа бусад төслүүд болон

Суурин төлөөлөгчийн газартай энэ талаар ярилцаж улмаар уг төслийн дизайн боловсруулах үед батлагдсан цалингийн хэмжээнээс цалин илт нэмэгдсэн байсныг тогтоосон. Энэ нь уул уурхайн салбар өргөжин тэлж англи хэлний өндөр мэдлэгтэй мэргэжилтнүүдийн тоо маш бага байгаатай холбоотой юм. Ийнхүү дорвитой өөрчлөлт хийлгүйгээр үндэсний зөвлөх нарыг сонгон шалгаруулж чадахгүйд хүрсэн тул АХБ-ны ажлын хэсэг эдгээр зөвлөхүүдийн ажлын хөлсийг дараах байдлаар зөвшөөрсөн: (i) урт хугацааны үндэсний 2 зөвлөхийн цалин эхний жилд 150%-аар нэмэгдэх ба жил бүр цалингийн хэмжээг дахин хянан үзэж үндсэн цалингийн хэмжээг 200% хүртэл; (ii) бусад үндэсний зөвлөхийн цалинг 200%-аар тус тус нэмэхээр 6 сард шийдвэрлэж, Санамж бичигт өөрчлөлт хийхээр тохиролцсоны дагуу өөрчлөлт хийж, төсвийн хуваарийг шинэчилж ирүүлсэн. Ийнхүү АХБ-тай зөвшилцөн зар сурталчилгааны нэмэлт төсөв батлуулан төслийн үндэсний олон нийтийн харилцааны мэргэжилтэн, санхүүгийн боловсролын судлаач нарыг сонгон шалгаруулах зарыг дахин 2012 оны 9 дүгээр сарын 4, 10 дугаар сарын 7-ны өдрүүдэд зарласны дагуу нийт 19 хүний материал ирсэн. ТУХ-оос баталсан төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд болон СЯ-ны төлөөлөл бүхий Зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний ажлын хэсэг нь АХБ-ны журмын дагуу Үндэсний олон нийтийн харилцааны зөвлөх Д.Гэрэлт-Од, Үндэсний санхүүгийн боловсролын судлаач Д.Дамдинжав нарыг шалгаруулснаар эдгээр зөвлөхүүд 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.

17. Төслийн эхлэлтийн тайлангаа Санхүүгийн боловсролын судлаач Д.Дамдинжав 2013 оны 02 дугаар сарын 13-ны өдөр, Олон нийтийн харилцааны үндэсний зөвлөх Д.Гэрэлт-Од 2013 оны 2 дугаар сарын 26-ны өдөр монгол хэл дээр тус тус төслийн багт ирүүлсэн.

### **1.2.2.3 Мониторинг үнэлгээний баг**

18. Төслийн баримт бичигт заасны дагуу мониторинг үнэлгээний багийг Азийн хөгжлийн банк шалгаруулан сонгох бөгөөд энэ ажил хийгдэж дуусаагүй талаар СЗХ-нд мэдэгдсэн. Энэ ажиллагаа удаашралтай байгаагаас үүдэн төслийн үр дүнг тодорхойлох гол гол үзүүлэлтүүдийг тогтоох, үнэлгээ хийх ажлууд төлөвлөгдсөн хугацаанаасаа хэт хоцорч ялангуяа мэдээллийн хэрэгсэлд тулгуурласан насанд хүрэгсдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх суурь судалгааны ажилд хүндрэл гарч болзошгүй байна.

### **1.2.2.4 Төслийн олон улсын зөвлөхүүд**

19. Төслийн баримт бичигт заасны дагуу олон улсын зөвлөхүүдийн сонгон шалгаруулалтыг АХБ явуулсан бөгөөд нийт 5 ОУ зөвлөх ажиллахаас 4-ийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсан. ОУ-ын зөвлөхүүд нь төсөл хэрэгжих хүртэлх хугацаанд гарсан өөрчлөлт болон цаг хугацааны байдалтай уялдуулан хийж гүйцэтгэх ажлын удирдамжид зарим нэг нэмэлт болон тайлбаруудыг төслийн захиралтай ярилцаж хэлэлцэж нэмэлт оруулсан.

#### **1.2.2.4.1. ХЗХ-ны чадавхижуулалт, сургалтын ОУ-ын зөвлөх**

20. Төслийн ХЗХ-ны чадавхижуулалт, сургалтын ОУ-ын зөвлөх Дин Мохан нийт 7 хүн-сар ажиллах бөгөөд 3 удаа Монголд ирж ажиллаад байна. Эхлэлтийн томилолтын үеэр (2012 оны 6 дугаар сард) СЗХ, МХСМТ, МХЗХХ, Хас банк зэрэг оролцогч байгууллагын төлөөллийг оролцуулан цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, дээрх өөр хоорондоо

ялгаатай үнэлгээ зэрэглэлийн системүүдийг танилцуулж, нийтлэг тал, зарчмыг хэлэлцүүлэн үнэлгээний системийн төслийг гаргасан. Монголд ажилласан 2 дахь томилолтын хугацаандаа(2012 оны 11-12 дугаар сард) хэлэлцүүлэг, туршилтын үнэлгээтэй танилцаж, туршилтад оролцож, үнэлгээний системийн эцэслэх, хэлэлцүүлэг хийх, үнэлгээчдийг сонгох талаар ажилласан.Түүний Монголд ажилласан буй 3 дахь томилолтын хугацаа нь 2013 оны 4 дүгээр сарын 22-оос эхлэн 5 долоо хоног байсан.ОУ-ын зөвлөхийн ажиллах хугацааг сунгаж, гэрээнд өөрчлөлт оруулаххүсэлтийг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн СЗХ-ны 1-2181, 1-2182 тоот албан бичгээр АХБ, СЯ-д тавьсан бөгөөд уг албан тоотын хариудСЯ-ны 2013 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 7-2/3414, АХБ-аас2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 289/13 тоот бичгээр тус тус нааштай хариу ирүүлсэн.

#### **1.2.2.4.2. ХЗХ-ны хяналт шалгалтын ОУ-ын зөвлөх**

21. ХЗХ-ны хяналт шалгалтын ОУ-ын зөвлөх Петер Штейн нийт 10 хүн-сар ажиллахаар гэрээ байгуулсан. Тэрээр 2 удаа Монголд ирж ажилласан. Эхлэлтийн томилолтын хугацаанд хууль эрх зүйн орчин, холбоод, Улаанбаатар болон орон нутгийн 3 ХЗХ-дын үйл ажиллагаатай танилцаж, өөрийн гүйцэтгэх чиг үүргээ тодорхойлсон. Петерийн ирүүлсэн эхлэлтийн тайлан мэдээлэл төдий, нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөөгүй, үндсэндээ чанарын шаардлага хангахгүй байсан тул тайланг дахин дэлгэрэнгүй ирүүлэх талаар мэдэгдэж, дахин тайланг ирүүлсэн боловч төслийн зүгээс шаардлага хангасан гэж үзээгүй. ОУ-ны зөвлөх Штейны 2 дахь томилолт нь 2012 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс 12 дугаар сарын 22-ны өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн. Энэхүү томилолтын зорилго бол СЗХ-ны газар дээрх хяналт шалгалт болон зайны хяналт шалгалтуудад үнэлгээ хийх байсан. Энэ хугацаанд ажилласан томилолтын ажлын тайлангаа явуулсан хэдий ч Хороогоор баталсан газар дээрх хяналт шалгалт хийж, үнэлгээ өгөх журамд анхаарах асуудал, тайлангийн агуулга, бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлох, тайлангийн загвар, шалгалт хийх аргачлал дээр нарийвчлан зөвлөгөө өгөөгүй үндсэндээ чанарын шаардлага хангахгүй байсан тул тайланг дахин дэлгэрэнгүй ирүүлэхийг мэдэгдсэн. Үүний дагуу тайланг дахин авсан ч зөвлөх ажил үүргээ төлөвлөлтийн дагуу хангалттай гүйцэтгэсэн гэж төслийн зүгээс үзээгүй. Хяналтын ОУ-ын зөвлөх Петер нь төслийн багт төгсгөлийн тайлангаа 2013 оны 2 дугаар сарын 16-ны өдөр ирүүлж АХБ-тай байгуулсан зөвлөхийн гэрээгээ цуцалсан.

22. Гэрээ цуцлагдсантай холбогдуулан түүний ажлын байрны зарыг 2013 оны 3 дугаар сарын 9-ны өдөр олон нийтэд зарласан. 2013 оны 3 дугаар сарын 20-д АХБ-аас зарын дагуу ирсэн материалуудын хураангуй жагсаалтыг ирүүлсэн. Гэвч эдгээр материалууд нь уг ажлын байранд тавигдсан шаардлага, ажлын туршлагыг хангахгүй байгаа, талаар төслийн багаас АХБ-нд мэдэгдэж ажлын байрыг дахин 2013 оны 4 дүгээр сарын 1-нд зарласан уг ажлын байран дээр Брайн Гэйтли сонгогдон шалгарч 2013 оны 5 дугаар сарын 6-аас 2013 оны 11 дүгээр сар хүртэл ажиллахаар АХБ-тай гэрээ байгуулсан. Монголд ажиллах эхлэлтийн томилолт нь 2013 оны 5 дугаар сарын 20-ээс 6 дугаар сарын 13 хүртэл байв. Тэрээр эхлэлтийн тайлангаа 6 дугаар сарын 12-нд ирүүлсэн.

#### **1.2.2.4.3. Олон улсын Санхүүгийн боловсролын зөвлөх**

23. Санхүүгийн боловсролын зөвлөх Лэсли Баркус АХБ –тай гэрээ байгуулан 6 сард Монголд 14 хоногийн хугацаатай ажиллаад холбогдох байгууллага, хүмүүстэй уулзалт хийсэн. Зөвлөх нь удаа дараа шаардуулж байж эхлэлтийн тайлангаа 9 сард ирүүлсэн нь төслийн баримт бичигт тодотгол хийх, төслийн хуваарийг АХБ-наас 7 сарын 30-ны дотор

эцэслэн шийдвэрлэхэд саад болсон. Харин энэ зөвлөх нь ажлаа өгсөн.

24. Санхүүгийн боловсролын зөвлөхөөр Ив Матью сонгогдон 2013 оны 04 дүгээр сарын 19-өөс 11 дүгээр сарын 5 хүртэл ажиллахаар АХБ-тай гэрээ байгуулсан. Эхлэлтийн томилолтоор 6 дугаар сарын 01-нээс эхлэн 3 долоо хоног Монголд ажилласан. Олон улсын боловсролын зөвлөх Ив Матью эхлэлтийн тайлангаа 2013 оны 6 дугаар сарын 24-ны өдөр Төслийн багт ирүүлсэн.

#### **1.2.2.4.4. Олон улсын хуулийн зөвлөх**

25. АХБ-аас Төслийн хуулийн зөвлөхөөр Патрик Мигэр 2012 оны 9 дүгээр сард сонгон шалгарсан. СЗХ нь ХЗХ-ны тухай хууль батлагдсанаас хойш хуулийн хүрээнд ХЗХ-ны зохицуулалт, хяналт шалгалт бусад холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулан хэрэгжүүлж байгаа тул хуулийн зөвлөхийн ажлын даалгаварт өөрчлөлт оруулан, ажиллах хүн сарыг багасгаж ажил үүргийн гэрээг 2,5 хүн-сарын хугацаатай байгуулсан. Тэрээр 3 дугаар сарын 5-аас 21-ийг дуустал Монголд ажилласан. Олон улсын зөвлөх Патрик Мигэр эхлэлтийн тайлангаа Төслийн багт ирүүлсэн.

26. Олон улсын зөвлөхүүдийн ажиллаж буй байдал, ажил гүйцэтгэх чиг хандлага, сэтгэл, өгч буй зөвлөмж, гаргаж буй тайлангаас харахад тэдний ур чадвар, хариуцлага харилцан адилгүй байгаа бөгөөд цаашид төслийн үр дүн эдгээр зөвлөхүүдийн ажиллагаанаас ихээхэн хамаарах тул төлөвлөсөн үйл ажиллагааг хийгдсэн эсэх, хийгдсэн бол чанарын ямар түвшинд хүрсэн эсэхийг харгалзан, АХБ нь СЗХ-оос ямар нэгэн үнэлгээ авч ажлын хөлс, томилолтын олгож байх нь зүйтэй гэж үзэж байгааг зориуд дахин тэмдэглэн хэлж байна.

## **II. Тайлант хугацаан дахь төслийн хэрэгжилтийн үйл явц**

### **2.1 Төслийн менежмент**

27. 2013 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн МХЗХҮХ, МХСМТ-ийн 2-13, 61 тоотоорирүүлсэн орон тооны бус ажиллах үнэлгээчид, сургагч багш, зөвлөхийн хөлс болон үнэлгээчдийн сургалтын төсөвшийдвэрлэх хүсэлтийн танилцуулгыг бэлтгэж ТУХ-ны 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн ТУХ-ны хурлаар асуудлыг хэлэлцүүлсэн.

28. Уг ТУХ-ны хурлаас өгсөн үүргийн дагуу СЗХ-ны хуралд төслийн үндэсний зөвлөх Т.Оюунчимэг нь ХЗХ-дын сургалтын хэрэгцээг тодорхойлох чадавхийн үнэлгээний систем, аргачлалын боловсруулалт, чадавхийн үнэлгээ хийх шаардлага, хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл, саналыг танилцуулсан.

29. Түүнчлэн 2013 оны 2 дугаар сарын 26-ны өдөр төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд болох МХЗХҮХ, МХСМТ-ээс Төслийн багт ирүүлсэн 2-13,61; 62 тоот хүсэлтийн дагуу СЗХ, СЯ, АХБ-ны төлөөллүүдтэй уулзах уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтаар төсөл хэрэгжүүлэгч ТББ-ын хувь оролцоо, үйл ажиллагааны зардал, урамшуулал, цалин хөлс болон ХЗХ-дын чадавхийн үнэлгээний сургалтын хөрөнгийн талаар хэлэлцсэн. Ингээд төсөлд оролцогч талууд уг асуудлаа албан бичгээр СЗХ, СЯ, АХБ-нд хүргүүлэхээр болсон. Үүний дагуу МХСМТ, МХЗХҮХ, МХҮНХ-оос төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны

зардал, худалдан авалтын талаар болон төслийн баримт бичгийн чадавхийн үнэлгээ, сургалтын төсөвт өөрчлөлт оруулах саналаа ирүүлсэн.

30. 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн СЗХ-ны хуралдаанаар төслийн хэрэгжилтийн явцын талаар танилцуулга хийсэн. Улмаар төслийн хэрэгжилтэд нөлөөлж буй бэрхшээлүүдийн талаар хөндөн хэлэлцсэн. СЗХ-ны хуралдаанаас эдгээр тулгамдаж буй асуудлууд, түүнээс гарах арга замаа эхлээд ТУХ-ны хурлаар хэлэлцээд шийдвэрээргэн танилцуулахыг үүрэг болгосон. Үүний дагуу ТУХ-ны 3 дахь удаагийн хурал 2013 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр хуралдаж төслийн баримт бичигт оруулах өөрчлөлт, мөн хэрэгжилт нь хоцрогдолтой байгаа ажил, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж уг хурлаар Төслийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, төслийн баримт бичигт тусгагдсан хийх ажлууд, хүрэх үр дүнг нарийвчлан тодорхойлох зорилгоор төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах саналыг бэлтгэх Ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хэсэг төслийн орон тоог оновчтой тогтоох, хавсарган гүйцэтгэж буй ажил үүргүүдийг салгах, төслийн орон тоог нэмэгдүүлэх, ажлын даалгаварыг шинэчлэх, төслийн гүйцэтгэгч агенлагууд болох МХЗХХ, МХСМТ-ийн үүрэг оролцоо, хариуцлага, үр дүнг тооцох механизмыг тодорхой болгон үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг шийдвэрлэх, төслийн хүлээгдэж буй үр дүнг тодорхойдох шалгуурын суурь болон зорилтот үзүүлэлтүүдэд шаардагдах тодруулга, төсвийн зардлын зүйл анги дотор өөрчлөлт тодруулга хийж саналаа ТУХ-ны дарга Х.Бум-Эрдэнэд танилцуулж улмаар саналыг СЗХ-ны 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1/1466 тоот бичгээр АХБ, СЯ-нд хүргүүлсэн.

31. Санхүүгийн салбарын газар зүйн зураглал хийх ажлыг 2013 оны 3 дугаар сарын 10-аас хөдөө орон нутгийн ХЗХ-дод чадавхийн үнэлгээ хийх ажлын хэсгийн удирдамжид үнэлгээний багт оролцогчид нь хөдөө, орон нутаг дахь албан ба албан бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн байршлын координатыг GPS ашиглан тогтоохдоо :

- a. Банкны салбар, тооцооны төв,
- б. ББСБ,
- в. ХЗХ,
- d. Барьцаалан зээлдүүлэх газар,
- e. Бусад зээлдүүлэгч байгууллага /сум хөгжлийн сан, төсөл хөтөлбөр г.м/,
- f. хувь хүн гэж зааж өгсөн. GPS тоног төхөөрөмжийг үнэлгээний багийн удирдагчид хүлээлгэн өгч, буцаан хүлээн авч уг тоног төхөөрөмж дээр бүртгэгдсэн байршлын мэдээллийг компьютер дээр буулган авч зураглал хийх бэлтгэл ажлыг хангасан.

32. АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас 2013 оны 4 сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулсан АХБ-ны зээлийн хөрөнгийн зарцуулалтын сургалтад төслийн зохицуулагчид хамрагдсан болно.

33. Төслийн худалдан авалтын төлөвлөгөө боловсруулах талаар 2013 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр АХБ-ны худалдан авалт хариуцсан мэргэжилтэн Бари Ахмадиу, АХБ-ны суурин төлөөлөгчийн газрын хөрөнгө оруулалтын эдийн засагч Э.Энэрэлт нартай уулзаж зөвлөмж авсан. Төслийн санхүү, захиргааны зохицуулагч Б.Хишгээ төслийн худалдан авалтын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Одоо ТУХ-ны хурлаар хэлэлцүүлэх гэж байна.



34. ТУХ-ны 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар хуралд оролцсон гишүүдын саналаар “Төслийн 2013 оны төлөвлөгөө”-г зарчмын хувьд баталсан. Уг төлөвлөгөө 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр эцэслэн боловсруулагдсан.

35. АХБ-ны Суурин төлөөлөгч Робэрт Шоэлхаммэр МХЗХҮХ, МХСМТ, ОУ-ын зөвлөх Дин болон үндэсний зөвлөх Т.Оюунчимэг нартай уулзах хүсэлт уламжилсны дагуу уулзалтыг 2013 оны 5 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа. Уг уулзалтаар төслийн гүйцэтгэгч байгууллагууд буюу МХЗХХ, МХСМТ-ийн үүрэг оролцоо, хариуцлага, үр дүнг тооцох механизмыг тодорхой болгох, эдгээр байгууллагуудын төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, үнэлгээний сургалтын төсөв зэрэг асуудлыг ярилцсан.

36. 2013 оны 5 дугаар сарын 03-ны өдөр АХБ-ны Суурин төлөөлөгч Робэрт Шоэлхаммэр, АХБ-ны суурин төлөөлөгчийн газрын хөрөнгө оруулалтын эдийн засагч Э.Энэрэлт нар Төслийн дарга Н.Оюунчимэг, төслийн зохицуулагч Б.Хишгээ, П.Байгалмаа нартай уулзсан. Энэ уулзалтаар төслийн бүтэц, 2010 онд батлагдсан хэрэгжилтийн хуваариас хэрэгжилт 2 жилээр хоцрогдолтой явж байгаа, зохицуулагчдын цалингийн нэмэгдэл, ОУ-ын зөвлөх сонгон шалгаруулахад АХБ хугацаа их алдаж байгаа, судалгааны баг, үндэсний зөвлөхүүдийн ажиллах хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж санал солилцов. Уулзалтын эцэст АХБ, СЯ, СЗХ, оролцогч байгууллага, төслийн баг оролцсон уулзалтыг ойрын үед зохион байгуулж эдгээр асуудлыг дахин ярилцаж шийдэлд хүрэх нь зүйтэй гэж үзсэн.

37. Төслийн 2012 оны гэрээ, ирсэн, явсан бичиг, судалгааны материалыг нэгтгэн цэгцэлж үдэн архивын нэгж болгон хадгалсан. Нийт 20 файл үүссэн.

38. Мониторинг баг, ХЗХ-ны хяналт шалгалтын ОУ-ын зөвлөх, Санхүү боловсролын зөвлөхийг сонгон шалгаруулахтай холбоотойгоор ажил үүргүүдийн даалгаварт төслийн багаас тайлбар, саналыг АХБ-тай солилцож харилцан зөвшилцсөн.

39. 2013 оны 5 дугаар сарын 05-ны өдөр АХБ-ны суурин төлөөлөгч Суурин төлөөлөгч Робэрт Шоэлхаммэр, АХБ-ны суурин төлөөлөгчийн газрын хөрөнгө оруулалтын эдийн засагч Э.Энэрэлт нар СЗХ-ны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Х.Бум-Эрдэнэ нартай уулзаж төслийн хэрэгжилт, төслийн багийн орон тоог нэмэгдүүлэх, төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах талаар ярилцсан.

40. 2013 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн Төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцах улирлын уулзалт, хэлэлцүүлэгт төслийн захирал Н.Оюунчимэг, зохицуулагч Б.Хишгээ, П.Байгалмаа нар оролцов. Уг уулзалтаар Төслийн дарга төслийн үйл явц, хүндрэлийн талаар компонент болгоноор дэлгэрэнгүй илтгэл тавьсан. Мөн төслийн хэрэгжилтийн явц, тулгарч буй хүндрэлийн талаар тавьсан асуултад хариулж, санал солилцов.

41. СЯ-ны 7-2/2530 бичгийг үндэслэн ТУХ-ны гишүүний бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж СЗХ-ны 5 дугаар сарын 23-ны хуралдаанаар хэлэлцүүлэх материалыг бэлтгэн хэлэлцүүлсэн боловч асуудал хойшлогдсон. Хурлын дараа СЗХ-ны 1-2182 тоот албан бичиг СЯ-наас ТУХ-ны бүрэлдэхүүнд оруулах шийдвэр гаргах түвшний эрх бүхий албан тушаалтныг дэвшүүлэх санал хүргүүлэв.

42. Төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах төслийн хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагын хоорондын уулзалтыг /СЗХ, МХЗХҮХ, МХСМТ, Төслийн баг, Төслийн үндэсний болон олон улсын зөвлөх/ 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдөр “Нүхт Корпорэйт” зочид буудалд зохион байгуулав. Уг уулзалтаар төслийн багийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах замаар орон тооны ажилтныг шинээр нэмэгдүүлэх; төслийн баримт бичигт заасанчлан МХЗХҮХ, МХСМТ-ийг төслийн хэрэгжүүлэгч байгууллага байхыг хэвээр хадгалж, улмаар цаашид ажил гүйцэтгэх гэрээ байгуулах замаар МХЗХҮХ, МХСМТ-ийн үйл ажиллагааны зардлын асуудлыг шийдвэрлүүлэх; хадгаламж, зээлийн хоршооны чадавхийн үнэлгээ хийх, үнэлгээний чиглэлээр сургалт явуулахад шаардлагатай байгаа төсөв болон сургалт, чадавхийн үнэлгээний олон улсын зөвлөхийн гэрээнд өөрчлөлт оруулах; төслийн төсөв, АХБ-наас санхүүгийн боловсролын суурь судалгаа хийх багийг сонгон шалгаруулах, санхүүгийн боловсрол болон олон ангит киноны агуулгыг боловсруулах ажил хойшлогдсон бөгөөд энэ ажлыг түргэвчлэх зорилгоор судалгааг хийх арга замын талаар хэлэлцсэн. Энэхүү уулзалтаас гарсан саналаа 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн СЗХ-ны 1/2181, 1/2182 тоот бичгээр СЯ болон АХБ-нд хүргүүлсэн.

43. Төслийн багийн зүгээс дараахь хурал, хэлэлцүүлэг, сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:

ТУХ-ны хурал

Огноо	Асуудлууд	Шийдвэрлэсэн байдал
2013.01.17	ТАНИЛЦУУЛАХ АСУУДАЛ 1. Төслийн хэрэгжилтийн хуваарь 2. Төслийн 2013 оны төлөвлөгөө ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД 1. Худалдан авалтын төлөвлөгөө 2. Үнэлгээний эцсийн хэлэлцүүлэгээс гарсан үр дүн, үнэлгээчдийн сургалт, үнэлгээ хийх талаар	- 2013.01.17-ны өдрийн ТУХ-ны тогтоол № 1 - “2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай” - 2013.01.17-ны өдрийн ТУХ-ны тогтоол № 2 - “Төсөв батлах тухай” - 2013.01.17-ны өдрийн ТУХ-ны тэмдэглэлээс № 2 - “Төсөв батлах тухай”
2013.02.06	ТАНИЛЦУУЛАХ АСУУДАЛ 1. Иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд, санхүүгийн боловсролын тойм 2. Санхүүгийн боловсролыг түгээж буй өнөөгийн нөхцөл байдал дүгнэлт, зөвлөмж 3. Телевизийн олон ангит киног хэрхэн бүтээх вэ?	
2013.04.04	Хоцрогдолтой хэрэгжиж буй ажлууд, түүний шалтгаан, гарах арга зам	- 2013.04.04-ний өдрийн ТУХ-ны тогтоол № 3 - “Ажлын хэсэг байгуулах тухай”

Хэлэлцүүлэг:

Огноо	Хэлэлцүүлгийн нэр, зорилго	Оролцогчид
2013.02.23	УБ хотын ХЗХ-дод хийсэн Үнэлгээний хэлэлцүүлэг: УБ хотын ХЗХ-дын үнэлгээнээс	23 хүн /Үүнээс хөдөө орон нутгаас 10 хүн/

	авсан сургамж, тулгарсан асуудлуудыг хэлэлцэх, шаардагдах нэмэлт зөвлөгөө, удирдамжаар хангах, орон нутагт үнэлгээ хийх хуваарь, аргачлалын талаарх мэдээлэл өгөх	
2013.04.26	Үнэлгээний тайланд ерөнхий анализ хийж, хийгдсэн ерөнхий анализ дээр хэлэлцүүлэг хийсэн.	14 хүн /МХЗХХ, МХСМТ, үнэлгээчид/
2013.06.13	Санхүүгийн боловсролын чиглэлээр хамтрын ажиллагааг нэмэгдүүлэх талаар	12 хүн /СХЗХҮХ, МБХ, МБ, ЕСБХБ, МДХ, МУЦАЭХ, ДБ, АХБ, СЗХ, төслийн баг

Сургалт:

Огноо	Нэр	Зорилго	Оролцогчид
2013.02.18	ХЗХ-ны үнэлгээчдийн сургалт	ХЗХ-ны чадавхийн үнэлгээний системийн дагуу үнэлгээ хийх аргачлалд сургах	28 хүн /Үүнээс хөдөө орон нутгаас 10 хүн/
2013.03.29	АХБ-ны суурин төлөөлөгчийн газраас худалдан авалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Батцэнгэлтэй хамтарч зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах тухай	Цуврал олон ангит кино хийх студи, судалгааны баг, зөвлөх сонгон шалгаруулахтай холбогдуулан Төслийн багийн хүсэлтээр	7 хүн /Төслийн баг, үндэсний зөвлөхүүд, СЗХ-ны холбогдох албан тушаалтнуудад/
2013.05.20-28	ХЗХ-ны сургагч багш бэлтгэх	Сургалтын эцэст оролцогсад нь сургалтын хэмжигдэхүйц зорилгыг тодорхойлох, сургах/сургах зарчмууд, сургалт төлөвлөн явуулах алхамууд, ХЗХ-дод хийх “ХЗХ-ны зарчмууд ба туршлагауд”, “ХЗХ-ны засаглал ба гишүүдийн оролцоо” сургалтуудыг биечлэн хийх чадвартай болох, , интернэтээр хийх сургалтын ажиллагааг тайлбарлан таниулах чадвартай болох	20 хүн /шалгуурын дагуу МХЗХХ, МХСМТ-өөс сургагч багшаар бэлтгэгдэхээр сонгогдсон хүмүүс/
2013.06.19	ХЗХ-ны зарчим, туршлагауд	Оролцогсдыг ОУ-ын болон Монголын ХЗХ-ны түүх, ОУ-ын ХЗХ-ны зарчим, үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, ХЗХ-ны онцлог, ялгааны талаар тайлбарлах чадвартай болгох, практик жишээнүүдэд үндэслэн ойлголт өгөх	20 хүн /ХЗХ-дын дарга, гүйцэтгэх захирлууд/
2013.06.20-21	ХЗХ-ны засаглал ба гишүүдийн оролцоо	ХЗХ-ны засаглалын тухай ойлголтыг сайжруулах, гишүүдийн идэвхи, оролцоо нь хадгаламж, зээлийн хоршооны сайн засаглалыг тогтоох суурь болдог гэсэн үндэслэлийг	24 хүн /ХЗХ-дын тэргүүлэгчид, хяналтын зөвлөлийн гишүүд/

		гаргаж ойлгуулах, сайн засаглалыг тогтоох нь ХЗХ-ны тогтвортой хөгжлийг хангах гол хөшүүрэг гэсэн ойлголтыг бататгах	
2013.06.28-30	“ХЗХ-ны зарчим, туршлагауд”, “ХЗХ-ны засаглал ба гишүүдийн оролцоо”	Оролцогсдыг ОУ-ын болон Монголын ХЗХ-ны түүх, ОУ-ын ХЗХ-ны зарчим, үйл ажиллагааны харьцаа үзүүлэлтүүд, ХЗХ-ны онцлог, ялгааны талаар тайлбарлах чадвартай болгох, практик жишээнүүдэд үндэслэн ойлголт өгөх ХЗХ-ны засаглалын тухай ойлголтыг сайжруулах, гишүүдийн идэвхи, оролцоо нь хадгаламж, зээлийн хоршооны сайн засаглалыг тогтоох суурь болдог гэсэн үндэслэлийг гаргаж ойлгуулах, сайн засаглалыг тогтоох нь ХЗХ-ны тогтвортой хөгжлийг хангах гол хөшүүрэг гэсэн ойлголтыг бататгах	28 хүн /Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулдаг “Арвин мөрөн” ХЗХ, “Анхдагч андууд” ХЗХ, “Баруун отог” ХЗХ-ны гишүүд/

44. Эдгээр хурал, семинар, хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулахтай холбогдсон зардлыг төсөвлөх, оролцогчдод зар хүргэх, ирц бүрдүүлэх, цаг товлох, зохион байгуулах газрыг товлох, материал бэлтгэж, олшруулах, тараах, тоног төхөөрөмж бэлтгэх, тэмдэглэл хөтлөх, шийдвэрийг албажуулах, зохион байгуулах зэрэг ложистик ажиллагаагаар Төслийн зохицуулагч нар хангаж ажиллалаа.

45. Төслийн зохицуулагч нар нь төслийн баримт бичигт тусгагдсан тус тусын ажил үүрэг, төслийн үйл явц, санхүүгийн удирдлага, зарцуулалт, худалдан авалт, зөвлөх сонгон шалгаруулалт, мониторинг болон үнэлгээ, төслийн нарийвчилсан хэрэгжилтийн төлөвлөгөө, төсөв, жилийн болон улирлын үйл явцын тайлангууд зэргийг цаг хугацаанд нь гаргаж Төслийн захирлын удирдлагад дор ажиллахаас гадна үндэсний зөвлөхүүд, олон улсын зөвлөхүүдэд эдгээр мэргэжлийн ажлын багт шаардлагатай уулзалтууд зохион байгуулах, уулзалт, сургалт, семинарын үеэр аман болон бичгийн орчуулга хийх, орон нутгаар ажиллахад холбогдох бусад ложистик туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

46. Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хамтран ажиллах хувь хүн, албан байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан үр дүнг тооцон ажилласан. Эхний хагас жилийн байдлаар нийт 28 гэрээ байгуулж ажилласнаас машин түрээслэх гэрээ 13, Сургалт, хурлын байгууламж түрээслэх гэрээ 2, Сургалтын материал боловсруулах гэрээ 6, орчуулга хийлгэх гэрээ 2, худалдан авалтын гэрээ 1, Оффисийн зориулалтаар түрээслэх гэрээ 1, сургалтад багшлах гэрээ 3 тус тус байгуулж ажилласан байна.

47. 2012 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх санхүү болон үйл ажиллагааны баримтад “Далай ван” аудитаас шалгалт орсон. Шалгалтын тайлангийн төсөл 2013 оны 6 дугаар сарын 24-ний өдөр ирсэн. Аудитаар дотоод хяналтын томоохон зөрчил, дутагдал эсвэл материаллаг сул тал гэж үзэхээр асуудлууд ажиглагдаагүй болохыг тайланг тэмдэглэсэн байна.

48. Төслийн үйл ажиллагааны хүрээнд хөдөө орон нутагт нийт 71 хүн ажилласан байна. Эдгээр хүмүүст томилолтын хуудас бичих, томилолт олгох, холбогдох мэдээллээрхангах, хүмүүстэй холбогдох, холбох зэрэг ложистис үйл ажиллагаагаар хангаж ажилласан.

## **2.2. БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ А: ХЗХ-ДЫН ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН СУРГАЛТ; ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

### **2.2.1 ХЗХ-ны үйл ажиллагаанд хийх газар дээрх, зайны хяналт шалгалтын системийг сайжруулах**

49. Эхлэлийн үе шатанд ОУ-ын хяналтын зөвлөх Брайн Гэйти Монголд ажиллахгурван долоо хоногийн хугацаантай СЗХ-ны төслийн багтай, ХЗХХ-ийн хянан шалгагч нартай хамтран ажилласан бөгөөд СЗХ, ХЗХ, МҮХЗХХ-ны холбогдох хүмүүстэй уулзалт хийсэн.СЗХ-ны ХЗХ-ны хэлтсийн дарга болон хянан шалгагч нартай уулзаж одоогийн зайны болон газар дээрх хяналт шалгалтын талаар мэдээлэл авах, шалгалтын тайлан, шалгалтын материалуудтай танилцаж, төслийн нийт хугацаан дахь хийх ажил үүргийн чиглэлээ тодорхойлсон.

50. Мөн төслийн зохицуулагч П.Байгалмаа, ХЗХХ-ийн хянан шалгагч нартай 2013 оны 05 дугаар сарын 26-аас 6 дугаар сарын 4-ний хооронд Өвөрхангай аймгийн Хархорин суманд байрладаг “БЭХ” ХЗХ дээр хийсэн газар дээрх шалгалтанд, 2013 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хотын “Есөн дэлбээ” ХЗХ дээр хийсэн газар дээрх шалгалтын үүрэг даалгаврын биелэлтийг шалгах шалгалтуудад биечлэн оролцсон. Тэрээр ХЗХ-дын санхүүгийн тайлан ерөнхий дүр зураг бүхэлдээ эргэлзээ төрүүлж байгаа тул орон нутгийн ХЗХ-дын үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт хийх нь нэн чухал гэж үзсэн.

51. Энэ газар дээрх шалгалт хийх явцад тэрээр уг шалгалтын багийн гишүүд болох БСГ-ын ХЗХХ-ийн хянан шалгагч нарын ажлын арга барилыг ажиглаж үнэлэлт өгсөн. Түүнчлэн газар дээрх хянан шалгалт нь илүү аудитын шалгалттай адилхан хянан шалгагч нар бүх баримт бичгийг нэг бүрчлэн шалгаж их ачаалалтай ажиллаж байна гэж дүгнэсэн.

52. Хяналт шалгалт/зардлын хүндрэл ачааллыг бууруулахад төрийн болон ТББ нь хоорондоо мэдээлэл солилцдог байх нь чухал гэсэн. Жишээлбэл, хэрэв СЗХ болон МХСМТ, МХЗХХ-той хамтран ХЗХ-дын үйл ажиллагаанд чадавхийн үнэлгээ хийхдээ олж тогтоосон асуудлуудыг СЗХ-нд мэдэгддэг байх. Нөгөө талаасаа СЗХ-ны хянан шалгагч нар ямарваа нэг асуудал, бэрхшээлийг олж тогтоовол энэ талаар МХЗХХ-оос тухайн ХЗХ-нд сургалт/туслалцаа үзүүлдэг байж болох юм гэж үзсэн.

53. Тэрээр ХЗХХ-ийн хянан шалгагч нартай уулзаж тэдний саналыг авч улмаар Хянан шалгагч нарт зориулсан тэнхмийн сургалтын төлөвлөгөөг урьдчилсан байдлаар боловсруулсан.

### **2.2.2 ХЗХ-ны зах зээлийн тогтворжилт**

54. Энэ хэсгийн хүрээнд 2011 онд батлагдсан Хадгаламж, зээлийн хоршоодын тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх замаар Олон улсын хуулийн зөвлөх Патрик Мигерээс ХЗХ-дын үйл ажиллагаанд одоо мөрдөгдөж буй болон шинээр гаргах шаардлагатай журам, заавруудтай холбогдуулан олон улсын стандарт, баримт бичиг, зарчмын хүрээнд санал,

зөвлөмж авах нь зүйтэй юм гэж үзэж СЗХ-ны БСГ-ын ХЗХХ-ээс ирүүлсэн санал хүсэлтийг хүргүүлсэн. Үүний дагуу хуулийн зөвлөх нь холбогдох шинжилгээг хийж, танилцуулгыг бэлтгэн ирүүлсэн. Энэхүү шинжилгээ, танилцуулгад төслийн захирал, БТХ-ээс саналаа өгсөн.

55. ОУ-ын хуулийн зөвлөх Патрик Мигерт Монголд 3 дугаар сарын 4-22-ны хооронд ажилласан ба энэ хугацаанд хууль, журмуудын хэрэгжилт, өөрчлөх санал зэргийг тандах үүднээс СЗХ, ХХБ, БСХС, МҮХЗХХ, МХСМТ, ХХЗХ, ХасБанк гэх мэт байгууллагууд дээр биечлэн очин уулзаж, мэдээлэл цуглуулж, санал солилцсон.

56. Түүнчлэн Төслийн зохицуулагч П.Байгалмаатай 2013 оны 03 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Монконкорд” ХЗХ, “Номин юнион” ХЗХ, Үндэсний зөвлөх Д.Дамдинжавтай 2013 оны 03 дугаар сарын 18-19-ны хооронд Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй “Таван ханхар” ХЗХ, Хэнтий аймгийн Жаргалт хаан суманд орших “Өсөн дэвжих жаргалтхаан” ХЗХ /татан буугдсан/, Өмнөдэлгэр суманд үйл ажиллагаа явуулж буй “Зоос хүрд” ХЗХ-дод биечлэн очин ХЗХ-дын үйл ажиллагаатай танилцаж, эрх зүйн орчны нөлөөллийг илрүүлэх зорилгоор ажилласан.

57. Эдгээр уулзалтууд, хууль, журмуудтай танилцан улмаар шинэчилсэн хуулийн хүрээнд боловсруулагдсан журмуудад ямар өөрчлөлтүүд оруулах, өөрийн эхлэлтийн тайлангийн бүтцийн талаар анхан шатны саналаа Төслийн даргатай солилцсон. 2013 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ОУ-ын хуулийн зөвлөх Патрик Мийгер эхлэлтийн тайлангаа ирүүлсэн.

58. Олон улсын зөвлөх Патрик Мийгерийн Патрик Мийгерийн шинэчилсэн хуулийн хүрээнд 8 журмуудад оруулах өөрчлөлтүүдийн саналуудыг Төслийн дарга, БСГ-ын БТХ-ийн хянан шалгагч нар танилцан хэт ерөнхий, хангалтгүй байна гэж дүгнэлт өгсний дагуу дахин боловсруулах хүсэлтийг хүргүүлсэн. Үүний дагуу 6 дугаар сарын 09-нд дахин саналаа ирүүлснийг СЗХ-ны БТХ-ийн хянан шалгагч нар хянан үзэж байна.

### **2.2.3 ХЗХ-ны зохицуулалт, МХЗХХ болон МХСМТ-тэй хамтран ХЗХ-дын чадавхийг бэхжүүлэх, үнэлгээ зэрэглэл тогтоох болон сургалт чиглэлээр**

59. 2013 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн СЗХ-ны хурлын 2 тоот тэмдэглэлээр ХЗХ-дын сургалтын хэрэгцээг тодорхойлох чадавхийн үнэлгээний систем, аргачлал боловсруулалт, чадавхийн үнэлгээ хийх ажлуудыг МХЗХХ, МХСМТ хамтран гүйцэтгэхийг үүрэг болгосон.

60. МХЗХХ болон МХСМТ-ийн тэргүүлэгчдийн 2013 оны 2 сарын 6-ны өдрийн хамтарсан хурлаар "ХЗХ-ны чадавхийн үнэлгээний систем", үнэлгээ хийх аргачлал баталсан.

61. Үнэлгээчдийг бэлтгэх сургалтыг 2013 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан бөгөөд сургалтад МХЗХХ, МХСМТ-өөс үнэлгээчинд тавигдах шаардлага хангасан нийт 28 хүн оролцсоноос 10 хүн нь хөдөө орон нутгаас оролцсон. Уг сургалтыг МХЗХХ, МХСМТ, төслийн баг хамтран зохион байгуулсан бөгөөд ХЗХ-ны чадавхийн үнэлгээний систем, үнэлгээ хийх аргачлалыг танилцуулан оролцооны аргад тулгуурлан хийсэн.

62. Уг сургалтын дараа бэлтгэгдсэн үнэлгээчид 2013 оны 2 сарын 19-нөөс 23-ны хооронд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт 65 ХЗХ-дод чадавхийн үнэлгээ хийсэн.

63. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-дод үнэлгээ хийсний дараа Үнэлгээчдийн дунд үнэлгээний явц, тулгарсан хүндрэл, асуудлын талаарх хэлэлцүүлгийг 2013 оны 2 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

64. 3 дугаар сарын 10-аас эхлэн хөдөө, орон нутагт ХЗХ-дод чадавхийн үнэлгээ хийх ажил эхлэсэн. Үнэлгээний баг нь МХЗХҮХ, МХСМТ-өөс тус бүр 1 гишүүн гарч хамтарсан баг бүрдүүлэн нийт 13 баг гарч ажилласан. Дархан, Сэлэнгэ, Завхан, Өмнөговь, Дундговь, Хөвсгөл, Булган, Архангай, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Сүмбэр, Увс, Төв, Ховд, Орхон аймгууд болон Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нийт 83 ХЗХ-дод үнэлгээ хийсэн.

65. Орон нутагт хийх үнэлгээний ажлын удирдамжид тухайн суманд байрлаж буй банк, ББСБ, ХЗХ, ломбард, зээл олгодог сангууд болон хувь хүмүүсийн байршлын зураглалыг GPS дээр тэмдэглэсэн.

66. ХЗХ-дын техник тоног төхөөрөмж, технологийн боломж хэрэгцээг судлах зорилгоор үндэсний зөвлөх Т.Оюунчимэг нь асуулга боловсруулсан. Энэ асуулгыг МХЗХХ хянасан бөгөөд орон нутагт үнэлгээ хийх явцад бөглүүлсэн. Үндэсний зөвлөх нь үнэлгээний явцад мониторинг хийх, үнэлгээчдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор Булган, Архангай, Хөвсгөл аймгуудын 7 ХЗХ-д чадавхийн үнэлгээ хийх үнэлгээний багтай хамтран ажилласан. Үндэсний зөвлөх нь үнэлгээний явцад үнэлгээчдэд шаардагдах туслалцаа дэмжлэг үзүүлэхээс гадна явцын мониторинг хийж, холбогдох үйл ажиллагаанд цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлсон.

67. ОУ-ын зөвлөх Дин Мохан Монголд ажиллах 3 дахь томилолтын хугацаандаа Үндэсний зөвлөх Т.Оюунчимэгтэй хамтран үнэлгээний тайланд ерөнхий анализ хийж, хийгдсэн ерөнхий анализ дээр МХЗХХ, МХСМТ, үнэлгээчидтэй 4 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

68. ХЗХ-дод хийх чадавхижуулах сургалтуудыг “ХЗХ-ны зарчим туршлагауд”, “ХЗХ-ны засаглал ба гишүүдийн оролцоо” чиглэлүүдээр уламжлалт аргаар хийх сургалтын модуль, сургагч багшийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалтын аргачлалын боломжит хувилбаруудыг тодорхойлох, холбогдох судалгааг МХЗХХ, МХСМТ, Үндэсний зөвлөх Т.Оюунчимэгтэй хамтран боловсруулсан. Мөн уламжлалт аргаар хийх дээрх хоёр сургалтыг зайны аргаар турших судалгааг МХСМТ-ийн ажилтан Бүрклей, Золжаргал нар хийсний дагуу Банк санхүүгийн академтай хамтран хийхээр хэлэлцүүлгээр тогтсон. Интэрнэтээр хийх сургалтыг Хэнтий, Төв, Архангай аймгуудад туршихаар шийдвэрлэсэн. Улмаар “ХЗХ-ны үйл ажиллагаанд мөрдөх бодлого, журмуудын үлгэрчилсэн аргачлал, гарын авлага”-ыг МХЗХХ-ны ажлын хэсэг боловсруулан үйл ажиллагаа явуулж буй бүх ХЗХ-дод USB, хэвлэмэл хувиар тараахаар шийдвэрлэсэн.

69. ХЗХ-ны сургагч багшийн сургалтыг 2013 оны 5 сарын 20-29-нд зохион байгуулсан бөгөөд сургалтаар УБ хот болон орон нутгийн нийт 19 сургагч багш бэлтгэгдсэн.

70. Боловсруулсан сургалтын модулийг Улаанбаатар хот болон Хөвсгөл аймагт тус бүр нэг удаа туршилт хийхээр төлөвлөсний дагуу Улаанбаатар хотод “ХЗХ-ны зарчмууд, туршлага” сургалтыг 2013 оны 6 сарын 19-ний өдөр зохион байгуулсан бөгөөд нийт 11 ХЗХ-дын 16 дарга, гүйцэтгэх захирлууд хамрагдсан.

71. Улмаар “ХЗХ-ны засаглал ба гишүүдийн оролцоо сургалтыг УБ хотод 2013 оны 6 сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд 12 ХЗХ-ны 24 тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүд хамрагдсан.

72. Хөвсгөл аймгийн Мөрөн хотод сургалтын модулийг турших сургалтыг 6 сарын 28-30-ны өдрүүдэд хийсэн. Уг сургалтад Хөвсгөл аймгийн “Арвин мөрөн”, “Анхдагч андууд”, “Баруун отог” ХЗХ-дын гүйцэтгэх захирал, тэргүүлэгчид болон хяналтын зөвлөлийн гишүүд гээд нийт 28 хүн хамрагдсан.

73. ЭнэУлаанбаатар хот болон Хөвсгөл аймагт хийгдсэн туршилтын сургалтад ХЗХ-ны багшаар бэлтгэгдсэн 4 сургагч багшаар ажилласан.

74. Мөн ХЗХ-ны үйл ажиллагаанд мөрдөх бодлого, журмуудын үлгэрчилсэн гарын авлага боловсруулах ажлын хэсгийг МХЗХХ-оос зохион байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар М.Рита (“Монкорд” ХЗХ-ны гүйцэтгэх захирал), гишүүдээр Б.Цэрэнлхам (“Алтан давалгаа” ХЗХ-ны дарга), Даваадолгор (“Монум” ХЗХ-ны эдийн засагч), Н.Уранцэцэг (“Арвиндэм” ХЗХ-ны гүйцэтгэх захирал), Оюунцэцэг (“Кредит юнион монгол” ХЗХ-ны гүйцэтгэх захирал) нар ажиллаж байна. 2013 оны 5-6-р саруудад Ерөнхий 3, Бодлогын 4, журам 9, бусад 1 баримт бичгийн загвар боловсруулахаар төлөвлөж, эдгээрийн жагсаалт, зарим баримт бичгийг ХЗХ-ны сургагч багшийн сургалтын оролцогчдоор хэлэлцүүлж саналыг авсан. 2013 оны 6 сарын 25-ны байдлаар баримт бичгүүдийн эхний төслүүд бэлэн болсон бөгөөд ажлын хэсгийн хэмжээнд эцэслэгдэх ажлыг 7 сарын 17-ноос хийхээр төлөвлөөд байна.

#### **2.2.4 Хадгаламж зээлийн хоршооны хууль, дүрэм, журмууд болон үйл ажиллагаа, төслийн үр ашгийн талаар телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах хүрээнд**

75. БТХ-ийн хянан шалгагч нар ХЗХ-ын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, журам, зааврын эмхэтгэлийн хэвлэлийн эхийг боловсруулан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, журам, зааврын эмхэтгэл” нэртэй 300 ширхэг ном хэвлүүлсэн. Эдгээр эмхэтгэлийг ХЗХХ-ийн хянан шалгагч нараар дамжуулан тусгай зөвшөөрөлтэй бүх ХЗХ-дод тус бүр нэг ширхэгийг тараасан. Мөн СЗХ-ны 33 орон нутгийн төлөөлөгчдөд тус бүр нэгийг өгсөн.

76. 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдөр №14/12 тоот Хамтран ажиллах гэрээг МҮОНРТ, ТВ-ийн Нэвтрүүлгийн хэлтэс болон JFPR9152-MON: Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл байгуулсны дагуу 2013 оны 02 дугаар сарын 18-ны өдөр МҮОНРТ-ийн эфирийн 20:00 цагийн “Цагийн хүрд зочин” нэвтрүүлэгт уг өдөр зохион байгуулагдсан үнэлгээчид бэлтгэх сургалтын талаар мэдээлэл хийсэн бөгөөд СЗХ-ны дэд дарга Г.Хэрлэн оролцож ХЗХ-ны эрх зүйн орчин, төрөөс үзүүлж буй үйлчилгээ, ХЗХ-ны өнөөгийн хөгжлийн шинэ үе шат, иргэдийн дунд байгаа ХЗХ-ны үйл ажиллагааны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, төслийн зорилго, хийгдэх ажлуудын талаар ярилцлага өгсөн.

77. Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогоор 2 дахь удаагийн нэвтрүүлгийг МХЗХҮХ-ны захирал Ш.Гоохүүтэй энэ оны 6 дугаар сарын 4 эсвэл 5-нд хийхээр төлөвлөсөн



боловч сонгуулийн арга хэмжээ эхлсэнтэй холбогдуулан уг нэврүүлгийг хаасан тул сонгуулийн дараа уг арга хэмжээг зохион байгуулахаар тохиролцсон болно.

78. 2013 оны 5 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд зохион байгуулсан ХЗХ-ны сургагч багшийн сургалт, ХЗХ-ны хөгжлийн асуудлын талаар ОУ-ын зөвлөх Деан Мохан “Bloomberg”-т 2013 оны 5 дугаар сарын 28-ны өдөр ярилцлага өгсөн. Энэ мэдээлэл news.mn вэб сайт дээр гарсан. Энэ ажиллагааг зохион байгуулахад АХБ-ны суурин төлөөлөгчийн газар туслалцаа үзүүлсэн.

## **2.3. БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ В: МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ТУЛГУУРЛАСАН НАСАНД ХҮРЭГСДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ**

### **2.3.1. Мэдээллийн хэрэгсэлд суурилсан насанд хүрэгчдийн санхүүгийн боловсрол**

79. Энэ хэсгийн хүрээнд СЗХ-оос хийсэн 3 аймгийн 60 гаруй сумдын иргэдээс авсан санхүүгийн боловсролын судалгаанд Үндэсний зөвлөхүүдийн зүгээс үр дүнг нэгтгэсэн.

80. Үндэсний боловсролын судлаач Д.Дамдинжав Банк, ББСБ, ХЗХ-дыг хамруулан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг тодорхойлсон судалгаа хийсэн бөгөөд гол гол санхүүгийн бүтээгдэхүүний хүү, нөхцлийг нэгтгэн өрсөлдөх чадварыг нь тогтоосон.

81. Түүнчлэн СЗХ-ноос бэлтгэн гаргадаг улирал тутмын нэгдсэн тайлан болон хоршоодын санхүүгийн гүйцэтгэлийг авч хоршоодын өсөлт, бууралтыг нэгтгэн судалсан.

82. Салбарын холбогдох байгууллагууд болох СЗХ, МБХ, МББСБХ, МХЗХХ, МХСМТ, ХасБанк, БСХС, Зарим хоршооны ажилтнуудтай биечлэн уулзаж зах зээлийн хөгжлийн талаарх ерөнхий хандлагыг гаргаж ирэхийн сацуу, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын эрхэм үүрэг, эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ, хийхээр төлөвлөсөн ажлууд, онцлог ялгаа, зорилтот бүлэг зэргийг судлаж Монголын өнөөгийн нөхцөлтэй харьцуулан үйл ажиллагааны хамаарах байдал, оролцох бололцоо зэргийг нэгтгэн гаргасан.

83. Сургалтын чиглэлээр ажилладаг ТББ-уудын үйл ажиллагаатай зайнаас танилцаж Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон Санхүүгийн чиглэлээр сургалт явуулдаг байгууллагуудыг зорилго, үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, зорилтот харилцагч зэргээр нь нэгтгэн дүгнэж, зэрэглэсэн бөгөөд төсөлд оролцох боломжийг тодорхойлсон.

84. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, санхүүгийн боловсролын талаар Монголд болон ОУ-ын түвшинд хийгдсэн судалгаануудыг нэгтгэн харьцуулж санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үндсэн ялгааг урьдчилсан байдлаар гаргасан.

85. Төслийн Удирдах Хорооны гишүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр төслийн зорилтот бүлгийг “насанд хүрсэн нийт ард иргэд” хэмээн тодорхойлсон. Монголд ард иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх санаачилга арилжааны цөөн хэдэн банкны зөвхөн өөрсдийн бүтээгдэхүүнээ дэмжсэн үйл ажиллагаагаар хязгаарлагддаг тул гадаадын туршлагыг интернэтээр судалж, олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх санаачилгуудын амжилтын түүх, туршлагыг судалж үр дүнг дээрх тайландаа тусгасан.

86. СЗХ-ноос ерөнхий санааг нь гаргасан ХЗХ-ны талаарх иргэдэд зориулсан гарын авлагын агуулгыг боловсруулж СЗХ-ны Бичил Санхүүгийн Газрын Бодлого Төлөвлөлтийн Хэлтэс, ХЗХ-ны Хэлтэс, МХЗХҮХ-ны Гүйцэтгэх Захирал Гоохүү нарт үзүүлж саналыг авч, тусгасан. Одоо СЗХ-ны Бичил Санхүүгийн Газрын даргын саналуудыг оруулснаар танилцуулгын агуулга эцэслэгдэж, эх бэлтгэл, хэвлэлтэнд шилжинэ.

87. СЗХ-ноос зохицуулалтын байгууллагууд, хамтран ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагууд, олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааг олон нийтийн харилцааны арга хэрэгсэлүүдийг ашиглан сайжруулахын тулд одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох болон энэ чиглэлээр хийвэл зохих ажлуудын талаар санал солицох уулзалтуудыг СЗХ-ны бүх алба, хэлтэсийн дарга, Монгол Банк, Сангийн Яамны холбогдох албан тушаалтануудтай хийсэн.

88. Мөн Төслийн баг, Үндэсний боловсролын судлаач, Олон улсын боловсролын зөвлөх Ив Матью нар хамтран Иргэдийн санхүүгийн боловсролын чиглэлээр ажилладаг Төр, захиргааны байгууллагууд, Донорууд, Мэргэжлийн холбоодын дунд зөвлөлдөх уулзалтыг 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулав. Уг уулзалтад СЗХ, СЯ, Монголбанк, Хасбанк, Дэлхийн банк, Азийнхөгжлийн банк, Банкуудын холбоо, МХЗХҮХ, МСМТ, Даатгалын холбоо, Банк бус санхүүгийн байгууллагын холбоо, харилцагчдын холбоо идэвхтэй оролцсон. Уулзалтын үеэр цаашид хамтран ажиллах хэлбэрийг тодорхойлж, гарсан санал санаачлагыг нэгтгэн үр дүнг уулзалтад оролцсон газруудад түгээв.

89. Уг уулзалтын дараа Монголбанк, Дэлхийн зөн, Хасбанк, Монголбанкнаас Фокус группын ярилцлагыг зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан бичил зээлийн үйлчилгээ авдаг 200 харилцагчийн жагсаалтыг гаргаж өгөхийг хүссэн албан тоотыг хүргүүлсэн. Энэхүү жагсаалтаас түүвэрлэн фокус группын хүмүүсийг сонгон фокус группын ярилцлагыг 7 дугаар сарын эхээр эхлүүлэхээр төлөвлөсөн.

90. Фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулахтай холбогдуулан дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- a. Фокус бүлгийн ярилцлага хийх аргыг тодорхойлох
- b. Оролцогчдыг сонгон шалгаруулах аргачлалыг тодорхойлох
- c. Мэдээлэл цуглуулах чиглэлээр хамтран ажиллах байгууллагуудыг тодорхойлж уулзалт хийн, албан бичиг хүргүүлж шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах
- d. Фокус бүлгийн ярилцлагын үеэр оролцогчдоос асуух асуултыг Санхүүгийн Боловсролын Судлаач, Олон Нийтийн Харилцааны Үндэслийн Зөвлөхүүд хамтран боловсруулав

91. Дэлхийн банкны Мэдээллийн сан (DataBank), ҮСХ-ны 1212.mn сайт дах мэдээлэл түгээх үйлчилгээнүүдийн мэдээллийн цар хүрээтэй танилцаж, холбогдох програм хангамжийг суурилуулж, шаардлагатай мэдээллийг гарган авах боломжтой эсэхийг судлав.

92. Санхүүгийн боловсролын мессежүүдийг тодорхойлохтой холбоотойгоор доорх судалгаануудыг хийж байна.

Үүнд:

- Credit болон borrowing-н хоорондын ялгааг тодорхойлох
- Төлбөрийн системүүдийн ерөнхий шинж чанаруудыг нарийвчлан тогтоох

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ хэрэгсэл болохынх нь тухайд мобайл банк, мобайл мөнгөний үйлчилгээнүүдийн өнөөгийн явцыг судалж тайлан хэлбэрээр тоймлов.

93. Дэлхийн банкны зүгээс хийсэн судалгааны эцсийн тайлантай дахин танилцаж санхүүгийн боловсролын жишиг үзүүлэлтийг тооцох боломжтой эсэхийг үзэв.

94. Олон нийттэй харилцаагаар дамжуулан төслийн зорилтот бүлэгт санхүүгийн боловсролын мессеж, мэдээлэл, мэдлэгийг хүргэх зорилгоор хийгдэх суурь судалгаагаар тодорхой болсон байх ёстой үр дүнгийн жагсаалтыг гаргасан.

95. Санхүүгийн боловсролын мессежийг боловсруулахтай холбогдуулан Санхүүгийн толь бичиг судлах ажлыг эхлүүлсэн.

96. Хаан банк даатгалын жуучлалын үйлчилгээ үзүүлэх болсонтой холбогдуулан Хаан банкын салбаруудаар санхүүгийн боловсролын эсвэл дан даатгалын боловсролтой холбоотой мэдээллийг олон нийтэд хүргэх боломжийн талаар уулзалт, ярилцлагууд хийсэн.

97. ХЗХ-ны хэвлэмэл танилцуулгын агуулга, тайлбар зургийг зурж, эх бэлтгэлийг хийж, хэвлэх газрын шалгуур үзүүлэлтийг төсөл хэлбэрээр боловсруулсан.

### **2.3.2. Газар дээрх судалгаа**

98. Газар дээрх судалгааны ажлын хүрээнд ямар нэг ажил 6 дугаар сар хүртэл хийгдээгүй. Учир нь судалгааны байгууллагыг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг боловсруулах, сонгон шалгаруулалтыг эхлүүлэх ёстой байсан боловч уг ажлын гол оролцогч болох Санхүүгийн боловсролын ОУ-ын зөвлөх 6 дугаар сарын 1-ээс эхлэн ажиллаж эхлээд байна. Түүнчлэн мониторинг үнэлгээний баг сонгогдсон байх ёстой боловч сонгогдоогүй байна. Энэ бүхнээс улбаалан судалгааны ажил, санхүүгийн боловсролын мессежийг тодорхойлох гэх зэрэг төслийн төлөвлөгдсөн ажлууд хугацааны хувьд хойшлогдоод байна.

99. Гэхдээ суурь судалгааг хийхтэй холбоотойгоор судалгааны багт зориулсан ажлын даалгавар бичих ажлыг хийж эхлүүлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд:

- а) төслийн танилцуулга, ерөнхий нөхцөл байдлын тойм
- б) санхүүгийн мессежийг тодруулахтай холбоотой гол гол асуултууд
- в) судалгааны багийн хийх ажлын цар хүрээ, тавигдах шалгуур зэргийг тогтоосон бөгөөд энэ хэсгүүдийг төслийн бусад бичиг баримтуудтай тулган нягтлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

100. Судалгааны ажлын даалгавар бичих ажилд “Монгол дахь охидын санхүүгийн боловсрол болон хадгаламж”-ийн чиглэлийн судалгааны тайлан, “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийг дэмжих төв”-өөс (OECD) боловсруулсан “Санхүүгийн боловсролын суурь судалгаа хийх аргачлал”-ыг үзэж танилцан, ашигласан.

101. Мөн Дэлхийн банкнаас Монгол улсад хийж буй ИСБ-ын судалгааны товъёог, хүснэгтэн мэдээллийн жагсаалт зэрэгтэй танилцаж хамрах хүрээг нь тандах судалгааг хийсэн.

Уг судалгааны үр дүнг Төслийн суурь судалгааны үр дүн байдлаар байдлаар ашиглаж болох эсэх талаар үнэлгээ хийсний үр дүнд Төслийн удирдлагуудад танилцуулж үүрэг, чиглэл авч ажиллана.

102. 6 дугаар сарын 1-нээс Олон Улсын Санхүүгийн Боловсролын Судлаач ажлаа эхэлсэн. Улмаар гацаад байсан бүх ажлууд эхэлж, урагшилна гэсэн хүлээлттэй байтал энэ 6 дугаар сарын сүүлээр үр дүн нь гарах Дэлхийн Банкны Санхүүгийн Боловсролын Судалгааны үр дүнг хүлээхээр шийдсэн. Учир нь Олон Улсын Санхүүгийн Боловсролын Зөвлөх төслийн баримт бичигт хийнэ хэмээн тусгасан судалгааг хийлгүй, Дэлхийн Банкны судалгааны үр дүнг суурь мэдээлэл болгоё гэсэн саналыг гаргасан ч Санхүүгийн Боловсролын Үндэсний Зөвлөх, Олон Нийтийн Харилцааны Үндэсний Зөвлөх нар төслийн зорилготой уялдсан судалгааг бие дааж хийх хэрэгтэй гэсэн санал тавьсан. Энэ асуудлыг Төслийн Удирдах Хорооны дарга Дэлхийн Банкны судалгааны үр дүнг Суурь Судалгааны суурь мэдээлэл болгон ашиглаж болох эсэхийг мэдсэний дараа хэрхэх эсэхээ ярилцая хэмээн шийдсэн.

103. Төслийн баримт бичгийн Б хэсгийн үйл ажиллагаа эхлэх нь суурь судалгааны үр дүнгээс шууд хамааралтай. Гэтэл 6 сарын сүүл болтол суурь судалгааны үр дүн тодорхойгүй. Гэсэн хэдий ч Олон Улсын Санхүүгийн Боловсролын Зөвлөх, Санхүүгийн Боловсролын Үндэсний Зөвлөх, Олон Нийтийн Харилцааны Үндэсний Зөвлөх нар санхүүгийн боловсролын 5 богино ТВ шторкууд, телевизийн олон ангит уран сайхны киноны туршилтын эхний 6 ангийн зохиолыг өөрсдөө боловсруулах гэх мэт саналууд гаргасан. Харамсалтай Худалдан Авалтын Төлөвлөгөө батлагдаагүйн дээр дээрх ажлуудын гүйцэтгэгчийг тендер шалгаруулж сонгох ёстой гэх мэт шалтгааны улмаас ямар нэг ажил хийгдээгүй.

### **2.3.3 Санхүүгийн боловсролын тухай телевизийн цуврал хийх тендерийг сонгон шалгаруулах**

104. Энэ ажлын хүрээнд эхний туршилтын 6 ангийг 2, 2-оор нийт 3 студиэр хийлгүүлж олон нийтэд цацах бөгөөд хамгийн өндөр үнэлгээ авсан студи цаашид үргэлжлүүлэн 24 ангийг хийх нь зүйтэй гэсэн санал 2013 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн ТУХ-ны хурлаар гарсан. Олон нийтийн харилцааны үндэсний зөвлөх Д.Гэрэлт-Од нь телевизийн олон ангит киноны зохиолыг бичих зохиолч, киног бүтээх студийг сонгон шалгаруулахад баримтлал болгох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах санал өгсөн.

105. 6 сарын сүүл болтол суурь судалгааны үр дүн тодорхойгүй байгаа ч Олон Улсын Санхүүгийн Боловсролын Зөвлөх, Санхүүгийн Боловсролын Үндэсний Зөвлөх, Олон Нийтийн Харилцааны Үндэсний Зөвлөх нар санхүүгийн боловсролын 5 богино ТВ шторкууд, телевизийн олон ангит уран сайхны киноны туршилтын эхний 6 ангийн зохиолыг өөрсдөө боловсруулах гэх мэт саналууд гаргасан. Төслийн худалдан авалтын төлөвлөгөө батлагдаагүйн дээр дээрх ажлуудын гүйцэтгэгчийг тендер шалгаруулж сонгох ёс журамтай тул ямар нэг ажил хийгдээгүй.

## **2.4. БҮРЭЛДЭХҮҮН С: МОНИТОРИНГ ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН, ТҮҮВЭРЛЭН ҮНЭЛЭХ:**

106. АХБ-аас үнэлгээний баг сонгон шалгаруулах талаар ТББ-т тусгагдсаны дагуу харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд 2012 оны 9 дүгээр сараас эхлэн ажиллуулахаар тусгагдсан. Төслийн багаас уг багийн сонгон шалгаруулалтын явцыг тодруулах зорилгоор 9-

өөс 12 дугаар сарын хугацаанд хэд хэдэн удаа имэйл явуулсан бөгөөд тодорхой хариу ирээгүй. 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдөр АХБ-аас уг тендерт оролцох саналаа ирүүлсэн зөвлөх компаниудын жагсаалтыг имэйлээр ирүүлсэн.

107. Мөн төслийн баримт бичигт тусгагдсан мониторинг үнэлгээний багийн 2 мэргэжилтэнийг хувь зөвлөхөөр сонгон шалгаруулах, ажлын даалгаварт өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг АХБ руу 2013 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр явуулсан. Түүнчлэн Мониторингийн багийн ажлын даалгавар, төсвийн талаар хэд хэдэн удаа АХБ, СЗХ уулзсан. Энэхүү хүсэлтийн талаар АХБ-аас албан ёсны хариу ирээгүй гэхдээ АХБ-ны ажилтан нар төслийн захиралтай ирж уулзан төслийн баримт бичигт тусгагдсан зарим ажлууд тодорхой бус, нарийвчлан дэлгэрүүлэх талаар зөвлөмж өгсөн ба төслийн баримт бичгийн дагуу мониторинг үнэлгээний багийг сонгон шалгаруулахаар шийдэн зарыг 2013 оны 3 дугаар сарын 9-нд гаргасанбөгөөд уг багийн ажил 2013 оны 7 дугаар сард эхлэх болно гэж мэдэгдсэн.

108. Түүнчлэн энэ асуудлыг Төслийн удирдах хорооны 2013 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцсэн бөгөөд төслийн баримт бичигт зааснаар “суурь судалгаа хийх байгууллагыг АХБ-ны зөвлөх сонгон шалгаруулах журмын чанарт суурилсан аргаар АХБ сонгон шалгаруулна” гэж тусгасанд өөрчлөлт оруулахаар санал гарч, хүсэлтийг АХБ-д тавихаар болно.

109. Ингээд уг судалгаа хийх багийн сонгон шалгаруулалтыг богино хугацаанд СЗХ удирдан явуулахаар өөрчлөлтийг оруулж хүсэлтийг төслийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ны 14/13 тоот бичгээр хүргүүлсэн. Энэ асуудлыг яаралтай шийдвэрлэхгүй бол төслийн төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдэхгүй хойшлогдох, зөвлөхүүдийн хийх ажлууд хүлээлтийн байдалд ороход хүрч байна.

110. Энэ дурьдсан асуудлыг яаралтай шийдвэрлэхгүй бол төслийн төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдэхгүй хойшлогдох, зөвлөхүүдийн хийх ажлууд хүлээлтийн байдалд ороход хүрч байна.

111. Хэдийгээр ямар нэгэн дорвитой ажил хийгдээгүй ч төслийн багийн зүгээс холбогдох мэдээллүүдийг СЗХ-ны БСГ-аас аваад файл үүсгэн хадгалж байна. Тухайлбал: СЗХ-ны FINA системээс тусгай зөвшөөрөлтэй нийт 168 ХЗХ-дын 2012 оны санхүүгийн хураангуй тайлангийн тэнцэл болон орлого зарлагын тайлан, СЗХ-ны БСГ-аас СЗХ-оос 2012 онд ХЗХ-дод хүргүүлсэн тайлангийн хариугийн хуулбар, ХЗХ-дын оршин тогтох байршил, хаяг, холбоо барих утасны судалгаа, ХЗХ-дын 2012 он болон 2013 оны эхний улирлын хадгаламж болон зээлийн хүүгийн судалгаа зэрэг болно.

#### **2.4.2.Төсөл хэрэгжилт дэх жендэрийн болон бусад бүлгүүдийн оролцооны үйл явц**

112. Төслийн үйл ажиллагаа нь иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах ялангуяа ядуу болон эмзэг иргэд, өрх гэр, эмэгтэйчүүдийг төслийн зоритот бүлэг болгон авч тэдэнд санхүүгийн үйлчилгээг энгийн, бодитой ойлгомжтой байдлаар хүргэхийг зорьж байгаа. Энэ ажлын хүрээнд эдгээр бүлгүүдтэй ганцаарчилсан буюу бүлгийн ярилцлагыг зохион байгуулж, хэрэгцээ арга замыг тодорхойлох ажлыг хийнэ.

### **III. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЛТЭД**

### **3.1 Төсөл хэрэгжилтэд тулгарсан асуудлууд**

113. Олон улсын зөвлөхүүдийг АХБ сонгон шалгаруулах үүрэгтэй бөгөөд АХБ-ны журмын баримталдаг. Харамсалтай нь журмын дагуу сонгон шалгаруулалт хийхэд хугацаа их шаарддаг учраас Санхүүгийн боловсролын ОУ-ын зөвлөх, Хяналт шалгалтын ОУ-ын зөвлөхийн сонгон шалгаруулалт хугацаандаа хийгдээгүй хойшлогдсон.

114. Мөн төслийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй, хурдан болгох зорилгоор дараах саналуудыг АХБ-нд уламжилсан. Үүнд:

- Төслийн багийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, ажилтнуудын орон тоог нэмэгдүүлэх
- Төслийн худалдан авалтын төлөвлөгөө батлах
- Төслийн баримт бичигт заасанчлан МХЗХҮХ /Монголын хадгаламж, зээлийн хоршооны үндэсний холбоо/, МХСМТ /Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв/-ийг төслийн хэрэгжүүлэгч байгууллага байхыг хэвээр хадгалж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах замаар МХЗХҮХ, МХСМТ-ийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлүүлэх;
- Хадгаламж, зээлийн хоршооны чадавхийн үнэлгээ хийх, үнэлгээний чиглэлээр сургалт явуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх
- Сургалт, чадавхийн үнэлгээний ОУ-ын зөвлөхийн ажиллах хугацааг сунгах
- АХБ-наас санхүүгийн боловсролын суурь судалгаа хийлгэх багийг сонгон шалгаруулах
- Мониторингийн түүвэрлэсэн үнэлгээ хийх баг сонгох
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын байршилыг тогтоон хадгалсан мэдээллийг цаашид юунд ашиглах нь тодорхой бус
- ТУХ-ны бүрэлдэхүүнд СЯ-ны төлөөлөл оруулах

### **3.2 Дараагийн улиралд хийх үйл ажиллагааны хөтөлбөр (Төслийн хэсэг тус бүрээр)**

115. ТУХ-ны 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв хэлэлцэн баталсан.

#### **Төслийн удирдлага**

- Санхүүгийн газарзүйн зураглал бэлтгэх
- Компьютер болон тоног төхөөрөмж, бусад худалдан авалт, тендерийг зохион байгуулах
- ТУХ-ны хурлыг зохион байгуулах
- Төслийн 3-р улирлын хэрэгжилтийн тайлан нэгтгэх, зохих газруудад хүргүүлэх
- Төслийн худалдан авалтын төлөвлөгөө батлуулах
- Мониторингийн багийг сонгон шалгаруулах
- Санхүүгийн тайлан
- АХБ руу нэмэлт санхүүжилтийн авах тухай санхүүгийн өргөдлийг боловсруулах
- 3-р улиралд гүйцэтгэх ажлуудын холбогдох зардлын тооцоог гаргаж батлуулах

### **ХЗХ-дын хууль, эрхзүйн холбогдолтой баримт бичгүүдийг шинэчлэх, сургалт, хэлэлцүүлэг**

- ХЗХ-ны хууль, бусад зохицуулалтын журмуудад өөрчлөлт оруулах, мөн олон нийттэй хэлэлцүүлэх санал боловсруулах, СЗХ-оос тайлбар авах, БСГ-тай хамтран дахин хэлэлцүүлэх
- ХЗХ-ны хууль, бусад зохицуулалтын журмуудад оруулсан өөрчлөлтийн төслийн талаар оролцогч талуудтай хамтран хэлэлцүүлэг хийх, / Улаанбаатар хот, аймгуудад / = 4 удаа
- Шинэчлэн боловсруулсан ХЗХ-ны зохицуулалтын журмуудад оролцогч талуудыг санал оруулан төгсгөлийн төслийг боловсруулж, СЗХ-ны дээд удирдлагад танилцуулж, эцэслэн батлуулах
- ХЗХ-ны хууль, журмуудыг сурталчлах аргачлалыг боловсруулах, олон нийт, ХЗХ-д болон гишүүдэд хэрхэн ач холбогдолтой болох талаар хэвлэл мэдээллийн хөтөлбөрүүд боловсруулахад зөвлөмж өгөх, хэрэгжүүлэх / ОНХЗ, БТХ, ОУХЗ/

### **ХЗХ-ны үйл ажиллагаанд хийх газар дээрх, зайны хяналт шалгалтын системийг сайжруулах**

- Одоогийн хэрэглэж буй газар дээрх хянан шалгалтын журам болон шинээр баталсан ХЗХ-ны хууль болон бусад журмуудтай харьцуулан судлах
- СЗХ-ны ХЗХХ-ын хянан шалгагч нарын ХЗХ-д дээр хийж байгаа газар дээрх шалгалтын явцтай танилцаж, тэдгээрийн гүйцэтгэж буй ажилд дүн шинжилгээ хийх
- СЗХ-ны хянан шалгагч нарын ажлын ур чадвар, ажлын үүргийн гүйцэтгэлийг сайжруулах хүрээнд сургалт явуулах
- Одоогийн хэрэглэж буй зайны болон газар дээр хяналт шалгалтын журмуудыг шинээр баталсан ХЗХ-ны хууль болон бусад журмуудтай харьцуулан судлах, эцэслэн боловсруулах
- Одоогийн хяналт шалгалтын системд үнэлгээ хийж, хэрхэн сайжруулах талаар зөвлөмж боловсруулна (хяналтын шалгалтын тайлагналтад тавигдах шаардлага, тайлагналт ба хариу арга хэмжээ, электрон тайлан, шалгалтын гарын авлага, шалгалтын давтамж, газар дээрх шалгалтын дараа авах арга хэмжээ, залруулга гэх мэт)
- Зөвлөхийн гаргасан зөвлөмжийн дагуу зайны болон газар дээрх хяналт шалгалтын системийн талаар туршилт явуулах
- СЗХ, МХЗХХ, МХСМТ, ХЗХ-дтой хамтран одоогийн болон шинэчилсэн хяналт зохицуулалт, журмууд болон гарын авлагын талаар олон нийтээр хэлэлцүүлэх
- Газар дээрх шалгалтын үеэр газар дээрх болон зайны хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй хэлэлцүүлэг хийх
- Шинэчлэн боловсруулсан зайны хяналтын системээр бүх ХЗХ-дод зориулж сургалтын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, явуулах

### **ХЗХ-дын чадавхийн үнэлгээ хийх, чадавхийг бэхжүүлэх**

- Үнэлгээ зэрэглэлийн дүгнэлт, сургамжийг МХЗХХ, МХСМТ, ХЗХ-дод хэлэлцүүлэг хийлгэх
- 3 чиглэлээрх бүсийн сургалтууд
- Бусад доноруудтай сургалтын талаар зөвлөлдөх

### **Газар дээрх судалгаа:**

- Судалгааны байгууллагыг сонгон шалгаруулах

### **УБ, аймгийн төв, сумын төв болон малчин иргэдийн санхүүгийн үйлчилгээ авдаг байдал, санхүүгийн боловсролын талаарх судалгаа:**

- Асуулгыг боловсруулах, СЗХ-той хамтран асуулгыг нягтлах,
- Иргэдээс судалгаанд хамрагдах бүлгийг тодорхойлох, судалгаа хийх, үр дүнг нэгтгэх, тайлагнах

### **Зорилтот бүлэг бүрт хүргэх санхүүгийн мэдээллийг тогтоох:**

- Оролцогч талуудаас зорилтот бүлэг бүрт хандан хийж байгаа ажил, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл авах, зорилтот бүлэгт хүргэх санхүүгийн боловсролын мэдээллийн саналыг хүлээн авах;
- Өмнөх судалгааны ажлын үр дүнд тулгуурлан зорилтот бүлэг бүрт хүргэх санхүүгийн боловсролын мэдээллийг нэгтгэн гаргах;
- ОУ-ын төвшинд зорилтот бүлгүүдэд хүргэдэг санхүүгийн боловсролын гол мэдээллүүдийг судалж, харьцуулах, мөн тэдний мэдээлэл хүргэдэг аргатай танилцаж харьцуулах, онлайн судалгаа; Нэгтгэн гаргасан санхүүгийн боловсролын мэдээллийг оролцогч талуудад танилцуулах, хэлэлцэх;
- Санхүүгийн боловсролын мэдээллүүдийг эцэслэх

### **Тодорхойлсон санхүүгийн боловсролын мэдээллүүдийн хэрэглэгчдэд ойлгомжтой байдал, хэрэгтэй байдлыг нь тодорхойлох үүднээс фокус группын судалгаа хийх**

- Фокус группүүдийг зохион байгуулах,
- Санхүүгийн боловсролын мэдээллүүдийг танилцуулж хэрэгцээтэй болон ойлгомжтой байдлыг тодорхойлж, дүгнэх
- Фокус группийн зүгээс шаардлагатай өөрчлөлтийн саналыг авч, дахин нэгтгэх
- Өөрчлөлтийг тусгасны дараах байдлаар эцсийн мессежүүдийг тогтоож оролцогч талуудад түгээх, танилцуулах

### **ТВ-ийн олон ангит кино бүтээх:**

- Санхүүгийн боловсролын тухай ТВ-ийн олон ангит киног бүтээх компанийг сонгон шалгаруулах
- Шалгарсан зохиолчид кино зохиол бичихэд нь санхүүгийн боловсролын мэдлэг, мэдээллийг тусгах талаас нь туслах, явцыг хянах, санал өгөх;
- Бэлэн болсон зохиолтой танилцаж, саналаа өгнө. Зохиолчтой зөвлөлдөн СЗХ, төслийн оролцогч талуудын саналыг тусган кино зохиолыг эцэслэн боловсруулж, батлуулна;

### **Иргэдэд хүрсэн мэдлэг, мэдээллийг үнэлэх:**

- Үнэлгээ хийх боломжит аргуудыг судлах, харьцуулах,



- Үнэлгээний аргачлал тус бүрд гүйцэтгэгч байгууллагуудтай уулзаж ерөнхий нөхцлийг тохирох;
- Үнэлгээг хамтран хийх гэрээ байгуулах ерөнхий нөхцлийг тогтоох;
- Үнэлгээний програм хангамж, техник хэрэслүүдийг гүйцэтгүүлэх;
- Гүйцэтгэсэн програм хангамж, техник хэрэгслийн ажиллагааг хянах, ойлгомжтой байдлыг шалгах, Функциональ тест; Иргэд хэрэглэж чадах эсэхийг шалгах; Фокус групп дээр турших;
- Үнэлгээний аргачлалд оруулах шаардлагатай өөрчлөлтийн саналуудыг боловсруулах;
- Эцсийн байдлаар үнэлгээний аргачлалуудыг хянах; Хяналт, Үнэлгээний багтай хамтран ажиллаж үнэлгээний аргачлалд дүгнэлт өгөх;

### **Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг олон нийтэд хүргэх**

Дэлхийн Банкны Санхүүгийн Боловсролын Судалгааны үр дүнг хийхээр төлөвлөж байсан Төслийн суурь судалгааны үр дүн болгон ашиглаж болох эсэхт Санхүүгийн Боловсролын Олон Улсын Зөвлөх, Санхүүгийн Боловсролын Судлаач, Олон Нийтийн Харилцааны Үндэсний зөвлөх нар хамтарсан, харилцан зөвшөөрсөн дүгнэлт гаргана. Түүнийгээ төслийн удирдах хороонд танилцуулна. Түүний дараа, хэрэв дэлхийн Банкны судалгааны үр дүнг ашиглахаар бол ямар үйл ажиллагаа, ямар хугацаанд хийх төлөвлөгөөгөө эцэслэн боловсруулна. Төлөвлөгөөнд дараах ажлууд багтана. Үүнд:

- Санхүүгийн боловсролын мессежийн хэлбэр, суваг, агуулгыг тодорхойлох
- Тодорхойлсон мессеж, түүнийг дамжуулах суваг, хэлбэрүүдээ турших;
- Туршилтанд ашиглах мессеж, суваг, хэлбэрүүдээ сонгох; Батлагдсан суваг эсвэл сувгуудаар түгээх санхүүгийн боловсролын мэдээллийн агуулгыг боловсруулах; Боловсруулагдсан агуулгыг шаардлагатай гэж үзвэл СЗХ-д танилцуулах, батлуулах; Туршилтанд хамруулах зорилтот бүлгийн төлөөллүүдийг тодорхойлох, Зорилтот бүлгийн төлөөллүүдийг цуглуулж, туршилтыг хийх;
- Туршилтын ажилд мониторинг, үнэлгээ хийлгэх; Үнэлгээний үр дүнд үндэслэн суваг, хэлбэр, мэдээллийг агуулгаа сайжруулах,

### **СЗХ-ны Бичил санхүүгийн газрын олон нийттэй харилцах, ХЗХ-ны хууль эрх зүйг олон нийтэд хүртээмжтэй хүргэх**

- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, журам, зааврын эмхэтгэл”-ийг ХЗХХ-ийн хянан шалгагч нараар дамжуулан тусгай зөвшөөрөлтэй бүх ХЗХ-дод тарааж дуусгана.
- МҮОНРТ-ийн эфирийн 20:00 цагийн “Цагийн хүрдийн зочин” нэвтрүүлэгт МХЗХҮХ-ны захирал Ш.Гоохүү оролцоно.

### **Мониторинг ба үнэлгээ**

- Чадавхийн үнэлгээний үеэр авсан ХЗХ-ын менежментийн "тэнхмийн" урьдчилсан сорил дээр үндэслэн бүх ХЗХ-ын чадавхийн түвшинг тогтоох суурь судалгаануудыг гаргах.
- СЗХ-ны улирлын тайлан дээр үндэслэн бүх ХЗХ-ын үйл ажиллагааны түвшинг тогтоох суурь судалгаануудыг гаргах

- СЗХ-ноос удирдан явуулсан иргэдийн санхүүгийн үйлчилгээний мэдлэг, салбар

№	Хэрэгжүүлэх ажлууд	Гүйцэтгэгч	Хугацаа	Биелэлт	Биелээгүй бол шалтгаан

бүрийн санхүүгийн төлөв байдлын талаар хийсэн судалгаан дээр үндэслэн суурь мэдээллийг боловсруулах

- Хөндлөн үнэлгээний баг дээр ажлууд дээр үндэслэн суурь судалгааны аудит хийх

#### **4. 2013 оныүйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

116. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь 2013 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн ТУХ-ны 01 тоот тогтоолоор батлагдсан. /Хавсралт 3/

117. Энэ батлагдсан төлөвлөгөөний дагуу 2013 оны эхний хагас жилийн биелэлтийг харуулбал:

1	СЗХ, МХЗХХ, МХСМТ, Хас банкинд үнэлгээний системийн сургалт	Т.Оюунчимэг, МХЗХХ МХСМТ	2013.02.	Биелсэн	
2	ХЗХ-дод үнэлгээ хийх	Т.Оюунчимэг, МХЗХХ МХСМТ	2013.02-	Биелсэн	
3	СЗХ, МХЗХХ, МХСМТ, Хас банктай хамтран үнэлгээ зэрэглэлд дүн шинжилгээ хийх	Т.Оюунчимэг, МХЗХХ МХСМТ, Дин, үнэлгээчид	2013.05	Биелсэн	
4	Үнэлгээ зэрэглэлийн дүгнэлт, сургамжийг МХЗХХ, МХСМТ, Хасбанкаар ХЗХ-дод хэлэлцүүлэг хийлгэх	Т.Оюунчимэг, МХЗХХ МХСМТ, Дин, үнэлгээчид	2013.05	Биелсэн	
5	Сургагч багшийн сургалтын хөтөлбөр боловсруулах,	Дин Мохан, Т.Оюунчимэг	2013.02-04	Биелсэн	
6	Сургагч багш бэлтгэх, Сургалтын модулиуд боловсруулах, Сургагчдын урьдчилсан сорил, Сургалтын хэлбэрүүдийг тодорхойлох, турших	Дин Мохан, Т.Оюунчимэг	2013.05-06	Биелсэн	
7	3 чиглэлээрх бүсийн сургалтууд	Т.Оюунчимэг, МХЗХХ МХСМТ	2013.06-12	Эхлээгүй	Санхүүжилт дутагдалтай, хэрэгжүүлэгч байгууллагуудын ҮА-ны зардал шийдэгдээгүйгээс хүлээгдэж байна.
<b>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг сайжруулах</b>					
1	2012 онд хийгдсэн 6 аймгийн иргэдийн санхүүгийн төлөв, санхүүгийн боловсролын судалгааны үр дүнтэй танилцах, ХЗХ-ны эрх зүйн орчинтой холбоотой бичиг баримтыг судлах	Д.Дамдинжав	2013.01	Биелсэн	

	Банкууд болон ББСБ-ын үзүүлэлтүүд бүхий тайлангуудыг нэгтгэж судалгаа хийх, Дэлхийн банкнаас хийгдэж буй Иргэдийн санхүүгийн боловсролын судалгааны үр дүнтэй танилцах, Төслийг гүйцэтгэгч болон бусад холбогдох байгууллагуудын хийж буй ажлыг тоймлон нэгтгэх, төсөлд оролцох оролцоог тодорхойлох, Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, Төслийн ерөнхий тоймыг боловсруулах, Гадаадын байгууллагууд иргэдэд санхүүгийн боловсрол олгох чиглэлээр ажилласан үр дүн, тэргүүн туршлагыг судлах, Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, Иргэдийн хоорондын уялдааг эцэслэх, Төслийн ерөнхий тоймыг эцэслэх	Д.Дамдинжав	2013.02	Биелсэн	
2	<b>Газар дээрх судалгаа:</b>				
	1. Суурь судалгаатай холбоотой ерөнхий ажлууд: Судалгаанд хамруулах зорилгот бүлгүүдийг тодорхойлох; Судалгаа хийх байгууллагуудыг сонгон шалгаруулах ерөнхий нөхцөл тодорхойлох; Судалгааны ерөнхий нөхцлүүдийг тодорхойлох,	Д.Дамдинжав, Д.Гэрэлт-Од	2013.03	Биелсэн	
	2. Судалгааны байгууллагыг сонгон шалгаруулах	Д.Дамдинжав, Д.Гэрэлт-Од	2013.04	Биелэж	Энэ чиглэлээр Дэлхийн банкны хийсэн судалгааг ашиглахаар болж байгаа бөгөөд эцсийн дүгнэлт 7 сард гарна
3	<b>УБ, аймгийн төв, сумын төв болон малчин иргэдийн санхүүгийн үйлчилгээ авдаг байдал, санхүүгийн боловсролын талаарх судалгаа:</b>				
	1. Асуулгыг боловсруулах, СЗХ-той хамтран асуулгыг нягтлах,	Д.Дамдинжав, Д.Гэрэлт-Од	2013.05	Биелсэн	Дэлхийн банкны тоон судалгааг ашиглахтай зэрэгцэн чанарын судалгааг өөрсдөө хийх зорилгоор фокус бүлгийн ярилцлага УБ, аймаг, суманд нийт 8 удаа зохион байгуулахаар болж байгаа бөгөөд асуулгууд, аргачлалыг боловсруулж дууссан

	2. Иргэдээс судалгаанд хамрагдах бүлгийг тодорхойлох, Судалгаа хийх, Үр дүнг нэгтгэх, тайлагнах	Д.Дамдинжав, Д.Гэрэлт-Од	2013.06-07	Биелэж байна	Аргачлал, судалгаа хийх газар, оролцогчдыг сонгох шалгуур үзүүлэлт зэргийг тодорхойлсон. Байгууллагуудаас харилцагчдын жагсаалт авах шатандаа явж байна. Төлөвлөгөөний дагуу 7 сард хийгдэж дуусна
4	<b>ТВ-ийн олон ангит кино бүтээх:</b>				
	1. Санхүүгийн боловсролын тухай ТВ-ийн цуврал бэлтгэх компанийг сонгон шалгаруулахад оролцох	Д.Гэрэлт-Од, Д.Дамдинжав	2013.03	Хойшилсон	
<b>Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг олон нийтэд хүргэх</b>					
1	Төслийн доорх оролцогч талуудтай уулзаж төслийн зорилтот бүлгийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, амжилтын түүх, хэрэгцээ шаардлагыг судлах, Төслийн зорилтот бүлгийг тодорхойлох, Олон улсад санхүүгийн боловсролын мэдлэгийг түгээх суваг болон хэлбэр, агуулгын тэргүүн туршлагыг судлах, Үйл ажиллагааны урьдчилсан төлөвлөгөө, төслийн зорилтот бүлэг санхүүгийн боловсролын мэдээллийг хүлээн авч буй хэлбэр, суваг, агуулгын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон баримт бичгийг боловсруулах, Дээрх мэдээлэл, судалгаанд дүн шинжилгээ хийж, дахин судалгаа хийх шаардлагатай бол үндэслэлээ гаргах	Д.Гэрэлт-Од	2013.01-02	Биелсэн	Тайлан боловсруулагдаж, ТУХ-нд танилцуулагдсан
2	Судалгааны үр дүнгийн тайланд үндэслэн зорилтот бүлэгт хүргэх шаардлагатай санхүүгийн боловсролын мессежийн хэлбэр, суваг, агуулгыг тодорхойлох	Д.Гэрэлт-Од	2013.06-	Биелэгү	Дэлхийн Банкны судалгааны үр дүнг хүлээж байна
<b>СЗХ-ны Бичил санхүүгийн газрын олон нийттэй харилцах, ХЗХ-ны хууль эрх зүйг олон нийтэд хүртээмжтэй хүргэх</b>					
1	Нэн чухал болон бусад шаардлагатай мессежүүдийг тодорхойлоход туслал, олон нийттэй харилцах үйл ажиллагааны талаар судлах, дүн шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах	Д.Гэрэлт-Од	2013.05	Хийгдэж	

2	Олон нийттэй харилцах үйл ажиллагаа бүрийн төсвийг боловсруулах	Д.Гэрэлт-Од	2013.05	Хийгдэж	
3	ХЗХ-ны хууль холбогдох журмуудыг зорилтот бүлэгт сурталчлан таниулах	Д.Гэрэлт-Од	2013.06-07	Хийгдэж	

## 5. Зөвлөхүүдийн төслийн үйл ажиллагаан дахь оролцоо

118. Зөвлөхүүдийн төслийн үйл ажиллагаан дахь оролцоо болон ажлын үр дүнд дараахь ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төслийн гүйцэтгэх нэгжид ажиллаж буй хүмүүсийн ажил үүргийн хуваарийг дахин тодорхойлж, зарим албан тушаалтныг шинээр бий болгохтой холбогдуулан 4 ажилтны ажил үүргийн хуваарийг боловсруулсан, үүнийг төслийн оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтанд танилцуулж санал, зөвлөгөөг тусгасан.
- Төслийн хэрэгжилтийн хугацааг дахин нарийвчлан тогтоож байгаатай уялдуулан Үндэсний зөвлөхүүд тогтоогоод байсан Үйл ажиллагааны төлөвлөгөө болон Төсвийг дахин шинэчилж, хянаж үүний танилцуулгыг бэлтгэн оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтанд танилцуулж санал, зөвлөгөөг тусгав.
- Төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө болон төсвийг бусад оролцогч талуудын төлөвлөгөө, төсөвтэй дахин уялдуулж, нэгтгэсэн.

## IV. САНХҮҮГИЙН БОЛОН ХУДАЛДАН АВАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

### 4.1. Худалдан авалтын тухай

119. Төслийн баримт бичигт заасны дагуу төслийн бараа, үйлчилгээний худалдан авалтыг АХБ-ны Бараа, үйлчилгээ худалдан авах журмын дагуу холбогдох бүх баримт бичгийг АХБ-аар хянан шалгуулж зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан авалтыг хийж байгаа болно. Суурин төлөөлөгчийн газрын худалдан авалт хариуцсан ажилтан төслийн худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд худалдан авалтын төлөвлөгөөг 2013 онд 3 дугаар сард худалдан авалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан боловч судалгааны баг сонгон шалгаруулах арга тодорхой бус учир эцэслэн гаргаагүй.

120. Харин 6 дугаар сард худалдан авалтын төлөвлөгөөг Төслийн зохицуулагч Б.Хишгээ АХБ-ны Э.Энэрэлт, Ж.Батцэнгэл нартай хамтран боловсруулсан. АХБ-ны СТГ-ын ажилтан Э.Энэрэлт Худалдан авалтын төлөвлөгөөг 6 дугаар сарын 21-ны 12 цагийн дотор батлуулах эс тэгвээс батлагдсанд тооцно гэсний дагуу ТУХ-ны дарга Х.Бум-Эрдэнэ ТУХ-ны гишүүдэд Худалдан авах төлөвлөгөөний төсөл, e-майлыг илгээ гэсний дагуу мэдэгдсэн. Энэхүү e-майлын хариуд ТУХ-ны гишүүн Ц.Мягмар-Очир, Ш.Гоохүү, Алтангааяа нар уг төлөвлөгөөг зайлшгүй ТУХ-ны хурлаар хэлэлцэх нь зүйтэй гэж санал ирүүлсэн тул уг төлөвлөгөө батлагдаагүй болно.

121. Уг төлөвлөгөөг 2013 оны 7 дугаар сарын 04-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.Худалдан авалтын төлөвлөгөөний төсөл Хавсралт 1

#### 4.2. 2013 оны эхний хагас жилийн санхүүжилт

122. 2013 оны эхний хагас жилийн санхүүжилтын товъёог Хавсралт 2

#### 4.3. Төслийн зардал (жилээр)

Зардлын нэр	2012	2013	2014	2015	Нийт
Төслийн хөрөнгө оруулалтын зардал	677,497.76	1,326,465.49	470,686.75	25,350.00	2,500,000.00
МУЗГ-ын үйл ажиллагааны зардал		44,801.69	29,259.98	7,168.84	81,230.52
Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардал	677,497.76	1,371,267.18	499,946.73	32,518.84	2,581,230.52

-----o0o-----